




**Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс**



**Уул уурхайн зарим салбарт хөдөлмөрийн  
хүрээн дэх суурь зарчмууд болон Монгол  
улсын хөдөлмөрийн хууль, тогтоомжинд  
заасан эрхийн хэрэгжилтийн төлөв  
байдалд хийсэн шалгалт  
судалгааны тайлан**



**Улаанбаатар**

**2003 он**



## **Агуулга**

### **Оршил**

Нэгдүгээр хэсэг

#### **Шалгалт-судалгааны арга зүй**

- Зорилго, зорилтууд
- Арга аргачлал, хамрах хүрээ, хугацаа
- Судалгааны мэдээлэл боловсруулалт

Хоёрдугаар хэсэг

#### **Шалгалт-судалгааны үр дүн**

2.1. Ашигт малтмалын уул уурхайн албан салбарт ажиллагсдын эрхийн төлөв байдал

- 2.1.1. Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжиж буй орчин
- 2.1.2. Эдийн засаг, үйлдвэрлэлийн зохион байгуулалт
- 2.1.3. Хөдөлмөрлөх эрхийн эрх зүйн орчин
- 2.1.4. Хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал
  - 2.1.4.1. Цалин хөлс авах эрх
  - 2.1.4.2. Амрах эрх
  - 2.1.4.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрхийн байдал
  - 2.1.4.4. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрхийн байдал
  - 2.1.4.5. Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчин нөхцөл
- 2.1.5. Ялгаварлан гадуурхах хандлага, албадан хөдөлмөрийн тухайд

2.2. Албан бус салбарт гар аргаар ашигт малтмал олборлогсдын эрхийн төлөв байдал

- 2.2.1. Албан бус салбарт гар аргаар ашигт малтмал олборлогсдын байршил, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн шинж, төлөв байдалд хийсэн судалгаа
  - 2.2.1.1. Хувиараа алт олборлогсдын байршил
  - 2.2.1.2. Хувиараа алт олборлогсдын нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн байдал
- 2.2.2. Гар аргаар ашигт малтмал хувиараа олборлох болсон шалтгаан, үндэслэл
- 2.2.3. Албан бус салбарт гар аргаар ашигт малтмал олборлогсдын хөдөлмөрлөх эрх болон бусад эрхийн төлөв байдал
  - 2.2.3.1. Ажил, амралтын горим
  - 2.2.3.2. ГААО-ын ажлын болон ахуй амьдралын орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдал
  - 2.2.3.3. Гар аргаар хувиараа алт олборлогсдын эрүүл мэндийн байдал
  - 2.2.3.4. Гар аргаар хувиараа алт болон бусад ашигт малтмал олборлогсдын зарим эрхийн төлөв байдал, тэдэнд тохиолдож буй бэрхшээл, дарамт шахалт
  - 2.2.3.5. Хүүхдүүд аюултай, хүнд нөхцөлд ажиллаж, хэрээс хэтэрсэн хүнд ачаа үүрч зөөдөг

Гуравдугаар хэсэг  
**Дүгнэлт, зөвлөмж**  
**Хавсралт**

---

© Монгол улсын Хүний эрхийн үндэсний комисс. 2003 он

## Оршил

Ашигт малтмал олборлолборлолт манай улсад эрчимтэй хөгжиж, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байна.

Монгол улсын Засгийн газраас 1992 онд “Алт” хөтөлбөрийг батлан гаргаснаас хойш алт олборлох уурхайнуудын үйл ажиллагаа эрчимжиж энэ салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн, тус чиглэлийн үйлдвэр компаниудын тоо ч өссөөр байна. 2002 оны эцэс гэхэд алтны 130 шахам аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, мөн онд уул уурхайн салбарт нийт 16394 хүн ажилласны 5190 хүн буюу 31.6 хувь нь зөвхөн алтны уурхайнуудад ажиллаж байжээ<sup>1</sup>. Үүгээр зогсохгүй хувиараа гар аргаар ашигт малтмал олборлох боллоо.

2003 оны байдлаар гар аргаар алт олборлож байгаа иргэдийн тоог зарим сумдын Засаг дарга, алт олборлож буй аж ахуйн нэгжээс авсан мэдээнээс үзвэл, ойролцоогоор 30 мянга орчим хүн энэ төрлийн ажил эрхэлж, 2002 онд 50 гаруй кг алт олборлож Монгол банкны эрдсийн санд тушаасан байна.<sup>2</sup>

Иймээс уул уурхайн албан болон албан бус салбарт ажиллагсдын хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийн төлөв байдал ямар түвшинд байгаа, энэ чиглэлээр хүний эрх ялангуяа хүний хөдөлмөрлөх эрхийн олон улсын суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хүний эрх зөрчигдөж буй шалтгааныг судлан, энэ эрхийг уул уурхайн салбарт хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт, эдийн засаг, нийгэм-сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь энэхүү судалгааг явуулах гол үндэслэл болсон юм.

Уул судалгааг Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос Улсын мэргэжлийн хяналтын газар, МҮЭ-үүдийн холбоо, Монголын ажил олгогч, эздийн нэгдсэн холбооны оролцоотойгоор явуулсан болно.

---

<sup>1</sup> АМХЭГ, Геологи-Уул уурхайн салбарын 2002 оны үйл ажиллагааны тухай, ЗГХА, АМХЭГ

<sup>2</sup> Гар аргаар ашигт малтмал олборлох тухай хуулийн төслийн талаарх танилцуулгаас

## **Нэгдүгээр хэсэг. Шалгалт-судалгааны арга зүй**

### **Шалгалт-судалгааны зорилго**

Энэхүү шалгалт судалгааны зорилго нь уул уурхайн үйлдвэр, компанид ажиллагсад болон хувиараа гар аргаар ашигт малтмал олборлогсдын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан эрх, хөдөлмөрийн хүрээн дэх суурь зарчмын хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, танилцан үнэлэлт, дүгнэлт өгч, хүний зөрчигдсөн эрхийг сэргээж засуулах, ажиллагсдын эрхийг бүх түвшинд хамгаалах арга хэмжээ авахуулахад оршино.

### **Шалгалт-судалгааны зорилтууд**

- Уул уурхайн албан болон албан бус салбарт хүүхдийг ажиллуулж байгаа бол тэдний эрхийг хэрхэн хангаж буй, энэ талаарх зөрчлийг илрүүлэн арилгах арга хэмжээ авахуулах
- Энэ салбарт хүмүүсээр хөдөлмөр эрхлүүлэхдээ ялгаварлан гадуурхах хандлага гаргаж буй эсэх
- Хүнээр албадан хөдөлмөр хийлгэж буй эсэх, тийм илрэл байгаа бол түүнийг тодруулах
- Хүний хөдөлмөрлөхтэй холбоотой суурь эрхийг хамтын гэрээ, хэлэлцээрт тусган хэрэгжүүлж, зохих журмаар эдлүүлж буй эсэх
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн аятай нөхцөлөөр хэрхэн хангасан байдал, энэ талаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авахуулах
- Чөлөөтэй эвлэлдэн нэгдэх ба зохион байгуулах эрхийн хэрэгжилт ямар байгааг тогтоох

### **Шалгалт-судалгааны аргачлал**

Энэхүү шалгалт-судалгаанд алтны уул уурхайн үйлдвэр, компаний ажиллагсад болон хувиараа алт олборлогсод хамрагдсан бөгөөд тэдгээрийг

түүврийн нэгжээр сонгохдоо Рэндомын буюу санамсаргүй түүвэрлэлтийн аргыг ашиглав.

Судалгаанд нийгмийн судалгааны уламжлалт аргууд болох анкетын асуулгын арга, ганцаарчилсан болон хэсэгчилсэн ярилцлага, ажиглалт аргуудыг ашиглан судалгааны үндсэн мэдээллийг цуглуулсан болно.

Судалгааны асуулгыг алтны уул уурхайн үйлдвэр, компаний ажиллагсад болон хувиараа алт олборлогсад тус бүрээр ХЭҮК-ын гишүүд, социологийн судлаачидтай санал солилцон асуумжийн логик бүтэц, хариултын хувилбаруудын үндэслэл зохимжтой эсэхийг шалган, дахин нягтлан боловсрууллаа.

### **Судалгааны хамрах хүрээ, хугацаа**

Энэхүү хэсэгчилсэн шалгалт- судалгааг ХЭҮК-оос Улсын мэргэжлийн хяналтын газар, МҮЭ-үүдийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны оролцоо, ОУХБ-ын туслалцаа, дэмжлэгтэйгээр хийв.

Шалгалт-судалгаанд Баянхонгор аймгийн Баян-Овоо сум дахь “Ажнай хурд”, “Тал булаг” ХХК-ны алтны уурхай, Бөмбөгөр сум дахь “Т энд Ч”, “Шагай”, “Селигдария Монголия”, “Одод” ХХК-ны Бумбатын алтны уурхай, Галуут сум дахь “Монгол-Болгар гео”, “Хангарьд”, “Баянхонгор гео”, “Зоос гоулд”, “Мондулаан трейд”, “Тулгажаргалант”, “Алтанцахир”, “Идэр гоулд”, “Одод” ХХК-ны Бухт, Дөвөнтийн алтны уурхайнууд болон мөн сумын “Баялаг-Орд” нүүрсний уурхай, Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлт дэх “Эрэл” ХХК-ны алтны уурхай, Төв аймгийн Заамар сум дахь “Мөнх-Оргил”, “Шижир-Алт”, “Алтандорнод Монгол” ХХК-ны алтны уурхай зэрэг нийт 20 уурхай, Говьсүмбэр, Дорноговь аймаг, Налайх дүүрэг дэх нүүрсний 8 уурхай, Дорноговь аймгийн Даланжаргалан сум дахь хайрга олборлох уурхай, мөн аймгийн Айраг сум дахь жоншны баяжуулах үйлдвэр, Хэнтийн аймаг дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр зэрэг 30-аад уурхайн 3840 гаруй ажиллагсдыг хамруулж, тэнд ажиллаж буй 170 хүнээс санал асуулга авсны зэрэгцээ албан бус салбар дахь гар аргаар хувиараа алт, жонш, нүүрс зэрэг ашигт малтмал олборлож буй 1500 гаруй хүнтэй уулзаж, 100 хүнээс бичгээр санал асуулга авлаа.

Шалгалт-судалгааг 2003 оны 10 дугаар сарын 13-аас 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэв.

## **Судалгааны мэдээлэл боловсруулалт**

Судалгааны мэдээллийг нэгтгэн боловсруулахдаа SPSS 10.0 for Windows программыг ашиглан гүйцэтгэлээ. Судалгааны мэдээллийг шалган, хагас нээлттэй болон задгай хэлбэрийн асуултуудыг кодлох, бүлэглэх, судалгааны анкетийн логик бүтцийг оруулах, шивэх, мэдээллийг дан болон нэг ба хоёр хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг эмперик түвшний судалгааг явуулдаг горимын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

## **Хоёрдугаар хэсэг. Шалгалт-судалгааны үр дүн**

### **2.1. Ашигт малтмалын уул уурхайн албан салбарт ажиллагсдын эрхийн төлөв байдал**

#### **2.1.1. Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжиж буй орчин**

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш амжилттай хөгжиж байгаа салбар бол уул уурхайн салбар. Энэ салбарын үйл ажиллагаа эрхэлдэг газруудын тоо сүүлийн жилд мэдэгдэхүйц өсч, 2003 оны эхний хагасын байдлаар ашигт малтмалын лиценз эзэмшигчид 3600 гаруй болж, алт олборлолтын хэмжээ эрс нэмэгдэж байна.

Зөвхөн бидний шалгалт, судалгаа хийсэн Баянхонгор аймагт ашигт малтмалын хайгуулын 269, ашиглалтын 38, Өвөрхангай аймагт хайгуулын 103, ашиглалтын 15 лицензыг байгууллага, аж ахуйн нэгж, зарим иргэд эзэмшиж байв.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрхлэхэд хайгуул, олборлолт, техник хэрэгсэлд ихээхэн хөрөнгө оруулалт, цаг хугацаа шаарддаг, нөгөө талаар лицензын болон ашигт малтмал ашигласны нөөцийн төлбөр, ашгийн татвар, газар ус ашигласны төлбөр төлж улсын төсвийн тодорхой хэсгийг бүрдүүлэх үүрэг хүлээдэг онцлогтой.

Шалгалт, судалгаанд хамрагдсан ашигт малтмал олборлодог үйлдвэр, байгууллагад хөдөлмөрлөх эрхийн хэрэгжиж буй орчинг дараах байдлаар тодорхойлж байна.

### **2.1.2. Техник-технологийн орчин**

“Монгол болгаргео” УҮГ, “Одод”, “Тэнд ч”, “Тал булаг” ХХК-ны алтны уурхайнууд, “Элдэв”, Шивээ овоогийн нүүрсний уурхайд Америк, Шинэ Зеланд, Япон, Солонгос зэрэг орнуудад үйлдвэрлэсэн уул уурхайн техник ашиглаж байна.

“Шижир алт” ХХК-ны Заамарын алтны уурхайд Драга, алхагч эксковатор болон сүүлийн үеийн бүтээл сайтай өөрөө явагч машин, механизмыг үйлдвэрлэлд нэвтрүүлж үйлдвэрлэлийн үр ашиг, ажиллагсдын хөдөлмөрлөх орчин нөхцөлийг дээшлүүлэхэд илүү анхаарч ажиллаж байна.



Зураг. Драга

Түүнчлэн “Шижир алт” ХХК-ны Заамарын алтны уурхай, “Шивээ-Овоо” нүүрсний уурхай, Бор-Өндөр, Айрагийн жоншны үйлдвэрүүдэд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл бүрдсэн, 120-1500 хүн байнга ажиллаж, ажиллагсад харьцангуй тогтвор суурьшилтай ажилладаг.

Харин бусад алтны болон нүүрсний уурхайнууд дунджаар 12-60, ид ачааллын үед 110 хүртэл тооны ажилтан, 10 орчим техникийн хөдлөх бүрэлдэхүүнтэйгээр 4-10 сарыг дуусталх хугацаанд үйлдвэрлэл явуулж байна. Уурхайнууд ажиллагсдаа хотоос болон орон нутгаас авч ажиллуулдаг, тэдний мэргэжил чадвар, ажлын дадлага туршлага харилцан адилгүй, дээрхи

уурхайнуудад машин техникийн эвдрэл саатал нэлээд гардаг, уул техникийн нөхцөл хүнд, ажлын нөхцөл тэр бүр эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа байдал ажиглагдсан болно.

Бусад уурхайнууд ОХУ-ын ЭО-4225, ЭО-5126, 33-22 эксковатор, Т-170, Т-130, ДЭТ-250 маркийн бульдозер, Краз-256 Б автосамосвал зэрэг техник болон ПГШ-50, СБ-12 маркийн угаах төхөөрөмж хэрэглэн хөрс хуулалт, олборлолт явуулж байгаа болно.

### **2.1.3. Хөдөлмөрлөх эрхийн эрх зүйн зохицуулалт ба түүний хэрэгжилт**

Монгол улсын 1992 оны Үндсэн хуульд “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх, цалин хөлс авах, амрах” хэмээн хүний хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийг баталгаажуулж заасны зэрэгцээ Монгол улсын нэгдэн орсон ЭЗНСЭТОУП болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 10 гаруй гэрээ, ковенцийн заалтууд, хөдөлмөрлөхтэй холбоо бүхий хүний эрхийн олон улсын суурь зарчмуудыг Хөдөлмөрийн хууль, тогтоомжид үндсэндээ бүрэн тусгасан байна.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-д *ажилтан нь “Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, өөрөө болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй”* гэж заасныг хэрэгжүүлэхэд мөн хуулийн 5 дугаар зүйлд “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй” гэж заасан энэхүү гол үүргийг хүлээж ажилладгийн зэрэгцээ мөн зүйлд “Ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх, ажилтнаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй”, мөн хуулийн 6-р зүйлийн 2-т “Ажилтан нь үнэнчээр хөдөлмөрлөх, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил, үүрэгтэй

нь холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг чанд сахин биелүүлэх үүрэгтэй” гэж гэрээнд оролцогч талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой заасан нь хөдөлмөрлөх эрхийн эрх зүйн орчин бүрдэхэд чухал ач холбогдолтой хөшүүрэг болж байгаа юм.

Тэрчлэн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулахгүй асуудлаар ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулсан тохиролцоог “Хамтын гэрээ” гэж Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулинд тодорхойлсон байдаг.

Хамтын гэрээ бол хөдөлмөрийн харилцааг зохицуулах нэг чухал хэрэгсэл болоод зогсохгүй энэ гэрээ нь ихэнх асуудлыг харилцан тохиролцох замаар зохицуулдгаараа ажил олгогч, ажилтан нарын аль алинд нь ач холбогдолтой хүний хөдөлмөрлөх эрхийг хангах чухал баримт бичиг болно. Жинхэнэ ёсоор байгуулсан хамтын гэрээ ажил олгогчийн нэр хүндийг хамт олны дунд өргөж, тэдгээрийн дур зоргоор аашлах явдлыг хязгаарлахад чиглэсэн зохицуулалт болдгоороо дэг журам тогтоон, ажиллагсдын нийгмийн хамгаалалд тавих анхаарлыг нэмэгдүүлж, тэдний бүтээлч идэвхи санаачилгыг өрнүүлэн улмаар бизнесийн түншүүдийн итгэлийг олох илүү боломж бүрдүүлдэг байна.

Гэтэл судалгаанд хамрагдсан ашигт малтмал олборлодог байгууллага, аж ахуйн нэгж болон холбогдох ажилтан, ажиллагсдын энэ талын мэдлэг хангалтгүй, хууль ёсны ашиг сонирхлоо эвлэлдэн нэгдэж, хамгаалах идэвхи, санаачилга дутмаг байна.

Шалгалт-судалгаанд хамрагдсан алтны 17 үйлдвэр, уурхайгаас ганцхан “Шижир алт” ХХК-ны Заамарын алтны үйлдвэр хамтын гэрээг зохих журмын дагуу байгуулан хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд Баянхонгор аймаг дахь “Монгол-Болгар гео” УҮГ, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, Айрагийн жоншны үйлдвэрээс бусад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад эрх ашгаа хамгаалуулах байгууллага болох ҮЭ байхгүй буюу байгуулаагүй, зарим нь татан буугдсан, ажилтны төлөөлөгчид ч байхгүй учир үндсэндээ хамтын гэрээгүй ажиллаж байв. Өөрөөр хэлбэл: 30

гаруй уурхайгаас хамтын гэрээтэй нь 5 буюу 16.6% нь байх бөгөөд судалгаанд хамрагдсан уурхайнуудын 83.4% нь хамтын гэрээ хэлэлцээр байгуулаагүй үйл ажиллагаагаа явуулж байна. Судалгаанд хамрагдагсдын 51.2% нь хамтын гэрээ, хэлэлцээр байгуулсан гэж хариулсныг зарим ажилтнуудаас нь лавлан асуухад хөдөлмөрийн гэрээтэй андуурч буруу хариулснаа хүлээж байв. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд хамтын гэрээг заавал байгуулах талаар заагаагүй нь хуулийн энэ заалтыг өнөөгийн нөхцөлд зохицуулан өөрчлөн боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаагийн илрэл юм.

Түүнчлэн ашигт малтмал олборлодог уурхайнуудад хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдөх, ажилтан нартай хөдөлмөрийн гэрээг хуулийн дагуу байгуулж ажиллах асуудал учир дутагдалтай хэрэгжиж байна. Шалгалт судалгаанд хамрагдсан байгууллагаас “Шижир алт”, “Алтан дорнод монгол” ХХК, “Монгол Болгаргео” УҮГ, “Хаан гарьд” ХХК-ны алтны зарим үйлдвэр, уурхай, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, Айрагийн жоншны үйлдвэр зэрэг 8 байгууллага, газар буюу 26 хувь нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5, 21, 48, 130 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу боловсруулсан хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдөн, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Харин аж ахуйн нэгж, байгууллага буюу 70 гаруй хувь нь дотооддоо хөдөлмөрийн харилцааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь хүний эрхийг зөрчих нөхцөлийг бий болгожээ. Зарим уурхай компаний захиргаад дотоод журам батлан мөрдөж байгаа гэх боловч тэр нь ажлын байранд нь байхгүй, байгаа журам нь уурхайд ажиллагсдын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аюулгүй ажиллагааг хангах болон ажил олгогч ажилтан нарын хөдөлмөрийн харилцааг зохицуулах баримт бичиг болж чадахгүй байна.

Хөдөлмөрийн гэрээний агуулга нь ажилтны хөдөлмөрлөх эрхийн зарим шаардлагыг хангахгүй байгаагийн зэрэгцээ хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомж, хамтын гэрээ хэлэлцээрт нийцүүлэх, хугацааг тохирох, гэрээг албан ёсны болгон нэг хувийг тухайн ажилтанд өгдөггүй нийтлэг зөрчил байсаар байна. Тухайлбал, “Монгол Болгар-гео” УҮГ-ын Жаргалантын уурхайн ажилтан нартай

байгуулсан хөдөлмөрийн гэрээний 1.8-д “... Захиргаа санал тавьсан нөхцөлд гэрээний хугацаа дуусгавар болно”, гэрээний тайлбарт “Хээрийн үйлдвэрлэлийн үед ажилтнуудыг орон сууцаар хангах үүргийг захиргаа хүлээхгүй” гэсэн заалт оруулсан нь ажилтан хүний эрхийг зөрчихөд хүргэсэн, “Алтан Дорнод монгол” ХК-ны хөдөлмөрийн гэрээний 1.7-д 3 сар хүртэл туршилтын хугацаа тогтоож сарын цалингийн 40 хувиар цалинжуулж туршилтын хугацаа дуусан цаашид ажиллахаар болвол дутуу олгосон 60 хувийг нөхөн олгохоор заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна.

Түүнчлэн гэрээний гол нөхцөлийг ажил олгогч дангаараа санаачлан урьдчилан бичиж гарын үсэг зуруулдаг, улирлын чанартай ажилд ажилтантай хөдөлмөрийн гэрээг заавал 3 сараар байгуулж дахин сунгадаг, гэрээний нэг хувийг ажилтанд олгодоггүй зөрчил нийтлэг байна.

Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж байгаа өмнө дурьдсан байгууллагуудын хувьд ч хөдөлмөрийн гэрээнд албан тушаал /ажлын байр/-ын онцлогт тохируулан ажилтны эдлэх эрх, тэдэнд үзүүлэх хөнгөлөлт, ажлын нөхцөл, хүлээх үүрэг, хариуцлага, өөр ажил түр орлон гүйцэтгүүлэх нөхцөл болзол, албан тушаалын онцлогийг харгалзан эд хөрөнгийн хязгаарлагдмал болон бүрэн хариуцлага хүлээлгэх үндэслэл, ажилтан нарын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар 2 талын хүлээх үүргийг тодорхой тусгаагүй дутагдал нийтлэг байна.

Зарим алтны уурхайнууд ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллуулж, тэдний эдлэх эрх, хөнгөлөлтүүдийг хязгаарлан хохироосон явдал ч илэрсэн юм.

Тухайлбал: Өвөрхангай аймгийн Уянга сум дахь “Эрэл” ХХКомпаний харъяа Өлтийн алтны уурхай ихэнх ажилтнаа ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллуулж байлаа.

**Жишээ:** Энэ уурхайд 8 жил ажиллаж байгаа бөгөөд сүүлийн 2 жил ажил гүйцэтгэх гэрээ болгосноос ээлжийн амралтгүй, өвдөхөд нийгмийн даатгалын тэтгэмж олгохгүй, мөн эрүүл мэндийн даатгал төлөөгүй учир төлбөртэй эмчилгээ хийлгэж, 10 цаг ажилладаг, илүү цагийн хөлс өгдөггүй, олон талаар хохирч байна.

“Эрэл” ХХК-ны Өлт дэх алтны уурхайн бульдорзөрчин Д.Батням

Судалгаанд хамрагдсан зарим компаниуд ийнхүү хамтын гэрээгүй, хүний эрхийн стандарт зөрчсөн хөдөлмөрийн дотоод журам мөрдөж, хөдөлмөрийн гэрээг зохих шаардлагад нийцүүлж байгуулаагүй явдал нь ажиллаж буй хүний хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийг хангаж, хөдөлмөрийн харилцааг зохицуулах баримт бичиг болж чадахгүй байна. Нөгөө талаар энэ нь уул уурхайн салбарт ажиллагсдын хөдөлмөрлөх эрх хязгаарлагдах, хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтад дурьдсан хүний эрх зөрчигдөх үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байна.

Түүнчлэн шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудаас “Хөдөлмөрийн маргаан таслах комисс” байгуулан ажиллаж буй байгууллага “Шижир алт” ХХК-иас өөр алга байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн маргаан гарсан тохиолдол сүүлийн 2 жил гаруй хугацаанд бүртгүүлээгүй байгаа боловч ажилчдаас ирсэн өргөдөл, гомдлыг захиргааны журмаар гол төлөв нэг талыг барьж шийдвэрлэсэн байх ба үүнээс дүгнэлт хийхэд цаашид хөдөлмөрийн маргаан гарахгүй гэх үндэслэл байхгүй байна.

## **2.1.4. Хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал**

### **2.1.4.1. Цалин хөлс авах эрх**

Шалгалт судалгаанд хамрагдсан байгууллагад ажилтны цалин хөлсийг хийснээр буюу цагаар тооцож хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгох зарчмыг баримтлан ажиллаж байна.

“Алтан Дорнод монгол” ХХК-ны Арнаймган, “Шижир алт” ХХК-ны Заамарын уурхай зэрэг томоохон алтны үйлдвэрийн ажиллагсдын үндсэн цалин харьцангуй өндөр, үйлдвэрлэлийн болон ажлын үр дүнгээр шагнал, нэмэгдэл

хөлсийг сар, улирал тутам олгож байна. Харин бусад уурхайнууд ажилтны цалин хөлсийг хөдөлмөр оролцооны итгэлцүүр хэрэглэх, хөдөлмөрийн нөхцөлийн болон хээрийн нөхцөлд нүүдэллэн ажилласны нэмэгдэл өгөх хэлбэрээр үндсэндээ олгож байгаа болно.

“Шижир алт” ХХК-ны Заамарын алтны уурхайд: Шөнийн цагийн нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хүртэл хувь, илүү цагийн хөлсийг хөдөлмөрийн хуулинд заасан хэмжээгээр, ажилтны буруу биш шалтгаанаар сул зогссон үеийн олговрыг үндсэн цалингийн 65 хувь, ажил орлон гүйцэтгэсний нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын цалингийн 30 хувиар олгох асуудлыг хамтын гэрээнд тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд эрдмийн зэргийн нэмэгдлийг 20 хувь, салбарын тэргүүний ажилтанд 20000, гавьяат, хөдөлмөрийн баатар цолтой хүнд 50000 төгрөгийн урамшууллыг сар бүр цалин дээр нь нэмж олгож байгаа нь хүний төлөө анхаарсан, ажилтны идэвхи санаачилгыг өрнүүлсэн арга хэмжээ болсон байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд “Алтан Дорнод монгол”, “Шижир алт” ХХК-ны зэрэг байнгын ажиллагаатай алтны үйлдвэрээс бусад уурхайд ажиллагсад 7 хоногт дунджаар 8-12 цаг илүү ажилладаг бөгөөд долоо хоногийн амралтын өдөр ажилласан хугацааны амралтыг биеэр нөхөн эдлүүлдэггүй, илүү цагийн хөлсийг ч олгодоггүй байна. Харин нүүрсний уурхай, жоншны үйлдвэрт ажиллагсад алтны үйлдвэр, уурхайд ажиллагсдыг бодвол илүү цаг харьцангуй бага ажиллаж, ням гараг, нийтээр амрах баярын өдөр амардаг байна. Хамтын гэрээгүй, нүүрсний уурхайн ажилчид хийснээрээ цалинждаг болон сул зогсолт, цайны завсарлага гээд ажил дээр байх цаг нь 10 болохоос яг үр бүтээлтэй ажилладаг цаг нь 8-аас хэтэрдэггүй тул илүү цагийн хөлс авах шаардлагагүй гэж ойлгодог ажилчид ч цөөнгүй тааралдаж байв. /”Налайх орд”, “Багануур-Налайх” ХХК-ны нүүрсний уурхай/

Түүнчлэн ажилтны буруу биш шалтгаанаар сул зогссон үед ажил олгогч сул зогсолтын олговор олгох байтал сул зогсолтын үед ажилчдыг амраадаг, бас хээрийн нэмэгдэл өгдөг тул илүү цагийн хөлс олгохгүй гэсэн тайлбарыг ч (“Ажнай хурд” зэрэг ХХК) өгч байсан болно.

Улирлын чанартай ажилладаг алтны болон нүүрсний уурхайнуудад шөнийн цагийн нэмэгдэл, сул зогсолтын үеийн олговор олгогдохгүй байгаа нь хамтын гэрээгүй, сул зогсолтыг нарийн бүртгэж тооцдоггүй, ажил олгогч болон ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, цалин нэмэгдэл хөлс, олговрын талаархи мэдлэг хомс байгаатай зохих ёсоор холбоотой байна.

Монгол улс 1969 онд нэгдэн орсон “Ижил хөдөлмөрт адил хөлс олгох тухай” Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 100 дугаар Конвенцид: Ижил хөдөлмөрт адил хөлс олгох, ижил хөдөлмөр эрхэлж буй эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил тэнцүү шан олгох тухай тусгайлан заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулинд эдгээр асуудал тодорхой тусгагдсан байдаг.

Цалин хөлсөөр ялгаварладаг тухай мэдээлэл байсны дагуу ажиллагсдаас санал асуулгын хуудсаар асуумж авах, ажилчидтай санал солилцох явцад: “Белаз” машины жолооч, гагнуурчны ажил хийдэг монгол, орос ажилчид харилцан адилгүй цалин (“Белаз” машины монгол жолооч сард 205\$, мөн машины орос жолооч 360\$) авдаг, харуулын ажилд ихэвчлэн монгол иргэд ажилладгийг судлах талаар “Алтан Дорнот монгол” ХХК-ны Арнаймганы алтны үйлдвэрийн зарим ажилчид хүсэлт гаргаж байсны дагуу судлахад: ОХУ-ын иргэн гагнуурчинд 320 ам.доллар өгч байхад Монгол улсын иргэн гагнуурчинд 175 ам.долларын цалин өгдөг нь тогтоогдсон юм.

Түүнчлэн цалин хөлсний хэмжээ бага, шагнал, нэмэгдэл олгодоггүй, хөдөлмөрийн хөлс хуваарилахад шударга бус ханддаг, цалингаа хугацаанд нь өгдөггүй, сүүлийн 2 жилд цалин хөлс буурах хандлагатай байгаа гэсэн санал, гомдлыг “Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, “Одод” ХХК, “Ажнай хурд” ХХК, “Эрэл” ХХК-ны алтны уурхайн ажилчид гаргаж байв. Ер нь уул уурхайн үйлдвэр, байгууллагад ажлын онцлог гэдгээр голлон шалтгаалж Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг дордуулан ажилтны цалинг сард нэг удаа (тогтоосон өдөрт) өгөхөөр хөдөлмөрийн дотоод журам, бүр хамтын гэрээндээ тусган хууль зөрчдөг хэвшил тогтсон байна. Түүгээр зогсохгүй тогтсон хугацаандаа цалин тавьж чадахгүй байх зөрчил цөөнгүй гардаг байна. Тухайлбал, “Селигдария Монголиа” ХХК-ны Өлзийт тохой дахь уурхайн зарим Монгол ажилтан 3 сар ажиллаад цалин аваагүй тохиолдол ч гарч байжээ.

**Жишээ нь:** Ажилд ороод 3 сар болж байгаа хэдий ч цалин аваагүй гэж ярьж байв. Уурхайн дарга нь “П” гэдэг Орос хүнээс асуухад улирлын эцэст үр дүнг харгалзан цалинг нь өгөхөөр гэрээ хийсэн гэж тайлбарлаж байв.

“Селигдария Монголиа” ХХК-ны туслах ажилтан С.Сүхбаатар

Үүнээс үзэхэд ажиллагсдын цалинг сард 2-оос доошгүй удаа тавьж олгож байхаар Монгол улсын хөдөлмөрийн тухай хуульд заасныг ноцтой зөрчиж байдаг нь уул уурхайн салбарын үйлдвэр, компаниудад цөөнгүй байдгийн тод жишээ юм.

Судалгаанд хамрагдсан ажиллагсдын 52.0% нь долоо хоногийн амралтын өдөр болон илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг олгоогүй буюу нөхөн амраагүй гэж хариулсан байна.


**Тодруулга:** “Шивээ-Овоо” ХК-ны хүнд даацын машин, механизмын хэсэг жолооч, машинчидтай уулзахад “Цалин бага, илүү цаг болон долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс бүрэн олгодоггүйн зэрэгцээ хөрс хуулалтын шороо болон нүүрс зөөсөн ачааны хэмжээг сийрэгжилт гэдгээр 50 гаруй хувийг нь хасч хохироодог” гэж ярьж байлаа.

**Тодруулга:** “Алтандорнод Монгол” ХХК-ны Монгол ажилчдыг ажлаас хоцрох, сахилгын бусад зөрчил гаргавал тэдний цалингаас 50% хүртэл суутгадаг гэж ярьж байв.

Судалгааны илтгэх хуудаснаас

Судалгаагаар ашигт малтмал олборлодог үйлдвэр, уурхайн ажиллагсдын 40 орчим хувь нь 21-30 насны иргэд, 74 хувь нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд цалин нь тэдний өрхийн орлогын гол эх үүсвэр болдог байна.

Зураг 2.1.1. Алт олборлох үйлдвэр, уурхайд ажиллаж байгаа судалгаанд хамрагдагсдын өрхийн орлогын эх үүсвэрийн бүтэц\* хувиар



Үүнээс үзэхэд алтны уурхайн компанид ажиллагсад өрхийн орлогынхоо дийлэнх эх үүсвэрийг буюу 62%-ийг алтны уурхайнуудад ажилласнаар олж авдаг байна.

#### **2.1.4.2. Амрах эрх**

ЭЗНСЭТОУП-ын 7-р зүйлд энэ эрхийг “амрах, зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баяр ёслолын өдөрт цалин хөлс олгох зэргийг хамаарна”, Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 4-т “амрах эрхтэй” зэргээр баталгаажуулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн Ажил, амралтын цаг гэсэн 5-р бүлгээр амрах эрхийг зохицуулан, мөн хуулиар нэг өдрийн үргэлжлэх ажлын цагийг 8 цаг, ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна хэмээн заажээ. Гэтэл уул уурхайн салбарт энэхүү хуулийн заалт зөрчигдсөөр байна.

Ихэнх уурхайнууд оргил ачааллынхаа үед хоёр ээлжээр ажиллахдаа нэг ээлжийг 10-12 цагаар буюу 12 цаг амарч, 12 цаг ажиллаж, долоо хоногт дунджаар 70-80 цаг ажилладаг гэсэн тооцоо гарч байна.

“Ажнай хурд” ХХК-ийн дизельчид Д.Ганбаатар, Б.Санжид нар гэхэд л 12 цагаар ажиллаж дизелийнхээ дэргэд амардаг. Энэ 2 хүн 1 жил гаруй ажиллаж байгаа боловч ээлжийн амралт авч үзээгүй.

Зөвхөн алтны уурхайн албан салбарт ажиллаж байгаа 120 гаруй хүнээс авсан судалгаагаар өдөрт 71.7% нь 8-аас дээш илүү цагаар ажилладаг бөгөөд 59.8% нь долоо хоногийн амралтын өдрүүдэд огт амардаггүй гэж хариулжээ. (ХЭҮК-оос хийсэн анкетийн судалгааны тайлангаас)

Дээрх алтны уурхайн салбарт ажиллагсдын дотроос зөвхөн судалгаанд хамрагдагсдын долоо хоногийн нийт ажилласан цагийг судлахад Монгол улсын хөдөлмөрийн тухай хуульд заасан хэмжээнээс дээд тал нь 86 цаг буюу дунджаар 27.39 цагаар илүү ажилладаг байна.

Ингэж илүү цагаар ажиллуулдаг, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баяр, ёслолын өдөр ажиллуулаад нөхөн амраадаггүй

шалтгаанаа уурхайн удирдлагууд тайлбарлахдаа алт олборлох үйл ажиллагаа нь дулааны улирал болох 4-10-р сарын хооронд жилд 6-7 сарын хугацаатай ажиллаад хүйтний улиралд ажил нь үндсэндээ зогсдог учир энэ үед нөхөн амардаг гэж ярьж байсан. Энэ нь зарим талаар үндэстэй боловч уурхайн ажил зогсох үед ихэнх ажилтнуудыг мөнгөтэйгээр ээлжийн амралтыг олгохын оронд ажлаас нь шууд чөлөөлж, хөдөлмөрийн гэрээгээ цуцлаад явуулдаг байна.

Алтны уурхайн албан салбарт ажилладаг 127 хүнээс авсан судалгаагаар 61 хүн буюу 48.0% нь ээлжийн амралтаа биеэр эдэлдэг, 12 хүн буюу 9.4% нь нөхөн олговор авдаг, үлдсэн 54 хүн буюу 42.5% нь ээлжийн амралт ч авдаггүй, нөхөн олговор ч авдаггүй байна.

Зарим уурхайнууд улирлын чанартай ажил гээд ажиллагсдын ээлжийн амралт болон амралтын нөхөн олговрыг олгодоггүй амрах эрхийг нь зөрчиж байхад зарим уурхай ажилд ороод заавал 11 сар ажиллаж байж ээлжийн амралт олгох журам тогтоон түүнийгээ баримтлан ажилтан хүнийг бололцоотой үедээ амрах эрхийг хязгаарладаг байна.

**Жишээ:** “Шивээ-Овоо” ХК дотоод журамдаа : “. . . Шинээр ажилд орогсод 12 сар ажилласны дараа эхний ээлжийн амралт эдэлнэ.” гэж заажээ.

#### **2.1.4.3. Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчин нөхцөл**

ОУХБ-ын “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай” 155 дугаар Конвенцид: “. . . хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны асуудлаар үндэсний бодлогын зорилго нь ажил үүргээ гүйцэтгэх явцад болон түүнтэй холбоотойгоор үүсэх ослоос, эрүүл мэндийг хохироохоос урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн орчноос бий болсон аюулын шалтгааныг аль болох бүрэн арилгах явдал юм.” гэсэн заалт, Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн 6-р бүлэг, 81-99-р зүйл, Засгийн газрын 2001 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөр” гэх мэт бусад холбогдох хууль, тогтоомжийн заалтын хэрэгжилттэй холбон судлав.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах талаар гарсан хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомж ашигт малтмал олборлодог үйлдвэр, байгууллагад харилцан адилгүй түвшинд хэрэгжиж байна.

“Шижир алт”, “Алтан дорнод монгол” ХХК, Бор-Өндөрийн болон Айрагийн уулын үйлдвэр ажлын байр нэмэгдүүлэх, ажиллагсдын ажиллах болон ахуйн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангахад анхааран хөтөлбөр төлөвлөгөөтэй, тодорхой хөрөнгө зарцуулан ажиллаж байна. Тухайлбал, эдгээр үйлдвэр, компани хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтан, их бага эмч орон тоогоор ажиллуулан, орон тооны бус зөвлөл, комисс байгуулж, сургалт зохион байгуулах, 3 шатны хяналт тавих, зааварчилгаа өгөх ажлыг үндсэнд нь хэвшүүлсэн, машин механизм, тоног төхөөрөмжийн паспорт, баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөн өргөж тээвэрлэх механизм, даралтат шугам хоолойд туршилт тохируулга, баталгаажилт хийлгэсэн, тоосжилт, дуу чимээ чичиргээг багасгах, гэрэлтүүлэг, ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлын нөхцөлийг сайжруулах бололцоотой зарим арга хэмжээг авдаг болсон байна.

“Шижир алт” ХХК гэхэд л жилийн цалингийн фондын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг хөдөлмөр хамгааллын арга хэмжээнд жил бүр зарцуулан, ажлын тусгай хувцсыг өвөл зуны улирлын загвараар оёдлын үйлдвэрт захиалан хийлгэж ажиллагчдад олгосон байна.

Гэвч бусад зарим алтны уурхайнууд аюулгүй ажиллагааны зааварчилгад гарын үсэг зуруулах, ажлын гутал, хувцас, малгай бээлий олгох, нормын сүү, тараг өгөх төдийгөөр аргацаан улирлын чанартай хөрс хуулалт, олборлолтын ажил явуулж байна. Машин, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах, паспорт техникийн бусад баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөхгүй, өргөж тээвэрлэх хэрэгсэл, даралтат шугам хоолойн туршилт тохируулгын ажлыг орхигдуулж баталгаажилт хийлгэхгүй байх, шөнийн нөхцөлд орчны гэрэлтүүлэггүй ажиллах, цахилгааны холболт ил задгай, тоног төхөөрөмжийн хаалт, хамгаалат бүрэн биш зэрэг аюулгүй ажиллагааны наад захын горим

алдагдах явдал “Мон дулаан”, “Т энд Ч” ба “Одод” ХХК-ны алтны уурхайд илэрсэн юм.

Түүнчлэн “Мон дулаан” ХХК-ын Ар харчулуут, “Одод” ХХК-ны Бухтын алтны уурхайн шороон ордын карьерийн хэсэгт нуралтыг тооцсон шатлал үүсгээгүй, уурхайн хана огцом, өнцөг үүсгэж технологийн горим алдагдсан байв.

Ил аргаар задгай орчинд алт олборлож байгаа Өлтийн уурхайгаас бусад уурхайд тоосжилтийг багасгах, агаар чийгшүүлэх, талбайг услах ажил огт хийгдээгүй, “Ажнай хурд”, “Өлт” гэх мэт олонх уурхайд усан буучийн ажилладаг байр нар, салхи, халуун хүйтэн цас борооноос халхлагдах боломжгүй, засварын болон дизелийн цех нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.

Харин эдгээр уурхайд үйлдвэрлэлийн явцад химийн хортой бодис хэрэглэдэггүй байна.

Ажиллагсдын ахуй нөхцөл алтны уурхай бүрт харилцан адилгүй. Зарим нь ердийн галлагаатай модон байшинд болон вагончик, гэрт амьдарцгаадаг. “Монгол Болгаргео” УҮГ-ын Жаргалантын уурхай, “Ажнай хурд” ХХК-ны алтны уурхайн дизельчид ажлын байрандаа, Арчулуутын уурхайн туслах ажилтан, тогооч нар гал тогооныхоо гэрт тус тус амьдарцгааж байв.

**Тодруулга:** Гал зуухны гэртээ тогооч, туслах ажилтан 2 хүн байрласан, уг гэрт ажилчид хамтдаа хоол ундаа идэж ууж байв. Тэнд угаалтуур байхгүй. Хүнсний материалыг гэрийн хаяанд хураасан. Хувцас, хөнжил гудас мөн гэрийн хаяанд хураалттай байлаа.

Баянхонгор, Галуут сум. Ар харчулуутын уурхай, 2003.10.14.

Ихэнх уурхайнуудад ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл маш хангалтгүй байна. Тухайлбал: Судалгаанд хамрагдсан алтны уурхайд ажиллагсдын 30.7% нь өөрсдийн ажлын нөхцөлийг эрүүл ахуйн хувьд тохиромжгүй шороо, тоосжилт ихтэй гээд дараахь нийтлэг зөрчил буюу бэрхшээл тохиолддог гэж хариулжээ.

- Гол төлөв гадаа ажилладаг учир хүйтэнд даарч, халуунд хэт халдаг;
- Шатах, тослох материалын угаарын хийд хорддог;
- Байнга чийгтэй нөхцөлд ажилладаг;
- Дуу чимээ, чичиргээ ихтэй
- Байнга босоогоор ажилладаг

- Байшинд ажилладаг цөөн хэсэг нь агааржуулагч хангалтгүй
- Ахуйн байр хүйтэн, тохигүй зэрэг нь бидний эрүүл мэнд, хөдөлмөрийн бүтээлд сөргөөр нөлөөлж байна гэжээ.

Уул уурхайн салбарын ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангаж, ажлын байрны нөхцөлийн онцлогоос хамаарч, түр амрах байр, ажлын тусгай гутал, хувцас болон хамгаалах янз бүрийн хэрэгслүүдээр хангаж, химийн хортой нөхцөлд ажилладаг ажиллагсдыг хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангах ёстой байдаг.<sup>3</sup>

Хөдөлмөр хамгааллын шаардлагатай хувцас, хэрэгслээр судалгаанд хамрагдсан нийт ажиллагсдыг хангах ёстойгоос дөнгөж 63.2% нь хангагдсан байв. Ажлын гутал, хувцас, бээлийгээр нийт ажиллагсдын 70.4%-83.2%-ийг хангасан ба хамгаалах хэрэгсэл болох малгай, каскаар хангавал зохих уурхайн механизмын жолооч нарын 33.3%-ийг, гагнуурчдын 37.5%-ийг, засварчдын 40.0%-ийг, усан буучдын 40.0%-ийг хангасан байв. Харин `Шижир-Алт` ХХК-ны алтны уурхайн драга дээр ажиллагсдыг хамгаалах хэрэгслээр 100.0% хангаж байна. Ажлын байран дээр анхны түргэн тусламж үзүүлэх наад захын шаардлагатай эм, бэлдмэл, боох материалаар нийт судалгаанд хамрагдсан ажиллагсдын дөнгөж 34.4%-ийг хангаж байна.

Тэрчлэн уул уурхайн ажилд хүнийг ажилд авахдаа урьдчилан нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт оруулж, эрүүл мэндийн байдлыг тогтоож, ажиллаж байх явцад нь жилд нэгээс доошгүй удаа эмнэлгийн хугацаат үзлэгт хамруулж байх шаардлагатай байдаг.<sup>4</sup> Гэтэл судалгаанд хамрагдсан нийт ажиллагсдын дөнгөж 26.0% нь шаардлагын дагуу эмнэлгийн урьдчилсан болон хугацаат үзлэгт орсон ба 24.4% нь л анх ажилд ороход эмнэлгийн үзлэгт орж байжээ.

Алтны уурхайд ажиллагсдын эрүүл мэндийн байдлыг судалж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт ажиллагсдын 34.6% нь ямар нэг өвчин эмгэгтэй гэж хариулсан бол 7.1% нь мэдэхгүй, эмнэлэгт үзүүлж байгаагүй, харин 55.1% нь өөрийгөө эрүүл гэж хариулжээ. Энэхүү судалгаагаар тэдгээр ажиллагсдыг


---

<sup>3</sup> Хөдөлмөрийн хуулийн 87, 90, 91 дүгээр зүйлүүдэд заасан.


<sup>4</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 92.1., Эрүүл мэнд, нийгэм хамгааллын сайдын А/206 тоот тушаалаар батлагдсан `Ажилтныг ажиллах явцад эрүүл мэндийн хугацаат үзлэгт оруулах ажил, үйлчилгээний жагсаалт`-ын 3.а-д заасан байдаг.

нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулаагүй тул дээрх эрүүл буюу өөрийнхөө эрүүл мэндийн байдлыг мэдэхгүй гэсэн бусад хүмүүсийг эс тооцвол судалгаанд хамрагдсан нийт хүний амын 1/3 нь ямар нэг өвчин эмгэгтэй байна. (Зураг 2.1.2-ыг үз)

Зураг 2.1.2. АУА-ын эрүүл мэндийн байдал



Зураг 2.1.3. АУА-ын өвчлөлийн байдал



Жич: Санал асуулгын дүнгээр дээрх 2 бүдүүвчийг гаргав.

Дээрх өвчлөлийн байдлыг судалгааны явцад санал асуулгын хуудсаар нарийвчлан асууж судалж үзэхэд бөөр болон шээсний замын өвчлөл хамгийн өндөр буюу нийт 44 өвчтэй ажиллагсдын 45.4% нь дээрх өвчнөөр өвчилсөн бөгөөд удаах байрыг зүрх судас, мэдрэлийн ядаргаа - 40.9%, үе мөчний өвчин - 38.6%, нүд, чих, хамар хоолойн өвчин - 34.1%, тус тус эзэлж байна. (Зураг 2.1.3-ыг үз)


Зарим томоохон уурхайн салбарт хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг бүрэн хангаагүйгээс мэргэжлээс шалтгаалах өвчин гарсаар байна.

Үүнийг тэдний дунд зонхилон тохиолдож байгаа 4 нэрийн өвчнөөр авч үзвэл:

Алтны дээрх судалгаанд хамрагдсан уурхайнуудад уг ажлыг хийхээс өмнө өвчилсөн хүмүүстэй харьцуулахад одоогийн энэ уурхайд ажиллаж байгаатай холбоотойгоор өвчилсөн бөөр, шээсний замын өвчтэй хүний тоо 7.5 дахин их, үе мөчний өвчтэй хүний тоо 6.5 дахин их, зүрх судас, ядаргаа, нүд, чих, хамар, хоолойн өвчтэй хүний тоо 1.5 дахин тус тус их байгаа бөгөөд эдгээр өвчлөлүүд нь мэргэжлээс шалтгаалах өвчин болоод байна. (Зураг 2.1.4.-ыг үз)


Энэ нь тэдний ажлын байрны нөхцөлтэй холбоотой задгай агаарт, цаг уурын хүйтэн халуун ямар ч нөхцөлд ус, чийгтэй орчинд удаан хугацаагаар хэт ачаалалтай ажиллах, химийн хортой хийн утаа, тортог, тоосонцрын дунд ажилласнаас даарч, хөрөх, амьсгалын дээд замын үрэвсэлт өвчин болон дээрх мэргэжлээс шалтгаалах өвчнүүдээр өвчлөх хандлага их гардаг байна.

Зураг 2.1.4. Судалгаанд хамрагдсан өвчтэй хүмүүсийн өвчлөлийн шалтгаан, зонхилон тохиолдож буй өвчнөөр



Энэхүү судалгаанд хамрагдагдсан өвчин эмгэгтэй хүмүүсийн 61.7 хувь нь мэргэжлээс шалтгаалж өвчилсөн, өвчний төрөл шалтгаан, өвчлөгсдийн тоо ажилласан жил, эрхэлж буй ажилтай нь шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлагатай байгаа нь анхаарал татаж байгаа юм. (Зураг 2.1.5-ыг үз)

Зураг 2.1.5. Өвчний шалтгаан




**Баримт:** Цэвэрлэгээндээ близна, комет, хлор их хэрэглэдэг учир миний нүд, хамар, хоолой их өвчилдөг болсон. Уурхайгаас бидэнд хор саармагжуулах сүү өгдөггүй.

Алтан-Дорнод Монгол`ХХК-ны алтны уурхайн үйлчлэгч Энхчимэг

**Өвчлөлийн байдлыг ажилласан жилээр авч үзвэл:**

Алтны уул уурхайн салбарт 3 хүртэл жил ажиллаж буй нийт 81 хүнээс 26.5-31.1% нь өвчтэй байсан бол 4 ба түүнээс дээш жил ажилласан нийт хүмүүсийн дотор өвчтэй хүний эзлэх хувь 53.8-85.7% болтлоо өссөн байгаа нь АУУА-ын өвчлөлийн байдалд тэдний эрхэлж буй ажил нөлөөлж байгааг баталж байна. (Зураг 2.1.6.-ыг үз)

**Зураг 2.1.6. Өвчлөлийн байдал, ажилласан жилээр**



**Тодруулга:** Бид байнга зогсоогоор ажилладаг, дуу шуугиан, тоосонцор маш ихтэй учир эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг  
“Монголросцветмет” нэгдлийн харъяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн баяжуулах заводын бутлуурын цехийн ажилтан Д.Э

Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн уулын болон баяжуулах үйлдвэр, бутлуурын цехэд дуу шуугиан, доргион, тоосонцор маш ихтэй боловч ихэнх ажилчид чихэвч, амны хаалт (маска)-аа зүүж хэвшээгүй байна. Тус үйлдвэрт одоогоор мэргэжлээс шалтгаалах өвчнөөр 310 гаруй хүн өвчилж хяналтанд байдаг бөгөөд эдгээрийн ихэнх нь Сүхбаатар аймгийн Бүрэн-Цогтын уурхайд ажиллаж байхдаа уг өвчнөөр өвчилсөн хүмүүс байв.

Ер нь судалгаанд хамрагдсан ихэнх уурхайнуудад ажиллаж буй хүмүүс хамгаалах хэрэгслээ хэрэглэдэггүйгээс болж мэргэжлээс шалтгаалах өвчинд өртөх нэг гол шалтгаан болж байна.

Зөвхөн “Шивээ-Овоо” ХК-ны хувьд л гэхэд нүүрсний уурхайн тоосжилт 10 мг/м<sup>3</sup> байхаас бутлах хэсэгт 17 мг/м<sup>3</sup>, уулын уурын зууханд 40 мг/м<sup>3</sup>, мужааны өрөөнд 12 мг/м<sup>3</sup> байна. Дуу шуугиан 85 децибеллээс хэтрэхгүй байх ёстой атал тэжээгч бункерийн дээд хэсэг, бутлах болон токарийн хэсэг, засварын цех, ТҮХ-ийн уурын зуух, мужааны өрөөнүүдэд 8-16.7 децибеллээр хэтэрсэн нь хэмжилтээр тогтоогдсон байна (Судлаачийн илтгэх хуудаснаас).

### **2.1.4.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрхийн байдал**

Уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрхийн төлөв байдлыг эхчүүдийг хамгаалах тухай 103 дугаар Конвенц, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбон судлан үзэхэд эмэгтэйчүүд гол төлөв үйлчилгээний чиглэлээр цөөн тоогоор хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа бөгөөд нэг хоёр компанийг эс тооцвол албан салбарт тэдний хөдөлмөрлөх эрх үндсэндээ зөрчигдөх явдал харьцангуй бага байдаг байна. Тэд уул уурхайн компаниудад үйлчлэгч, тогооч, лаборатори, халуун ус, угаалгын зэрэг газарт гол төлөв хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байна.

Судалгааны явцад зарим компанид эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх зөрчигдөхөд хүрч буй илэрлүүд ажиглагдсан байна.

**Тодруулга:** “Ажнай хурд” ХХК-д ажилладаг тогооч эмэгтэй өдөр бүр 10-аас доошгүй цагаар ажилладаг боловч илүү цагийн хөлс авдаггүй, сард 40000 төгрөгөөс дээшгүй цалин авдаг.

Алтны уурхайн компанид ажилладаг 120 хүнээс санал асуулга авахад 26 нь буюу 21.7% нь эмэгтэйчүүд байжээ.

Харин албан бус салбарт буюу гар аргаар хувиараа ашигт малтмал олборлож буй эмэгтэйчүүдийн хувьд тэдний эрх зөрчигдөх явдал түгээмэл байгааг энэ тайлангийн 2.2-т тодорхой дурьдав.

Судалгаанд хамрагдсан алт, нүүрс, жонш олборлодог уурхайнуудад эмэгтэйчүүдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг зөрчсөн тохиолдол гараагүй болно.

Харин “Алтан Дорнот монгол” ХХК-ны Арнаймганы алтны уурхайн автомат тохируулагчтай уурын зууханд галлагчаар эмэгтэй хүн ажиллаж байсан тохиолдол гарсан юм.

**Баримт:** Би энэ ажлыг 3 жил хийж байгаа. Өдөрт 12 цаг ажилладаг. Миний сарын цалин эрэгтэйчүүдийнхээс арай бага 165\$ (эрэгтэйчүүдийнх 195\$) байдаг. Ажлын нөхцөл хүнд, маш их дуу шуугиантай. Үйлдвэр ажлын хувцас, каск малгай өгдөг. Харин чихэвч өгдөггүй.

Г.Мөнхтуяа, Уурын зуухны галлагч, нас 30

Тэрчлэн зарим компани хөдөлмөрийн дотоод журмандаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн заалтыг зөрчсөн заалт оруулсан нь илэрсэн юм. Жишээ нь: “... 8.1.11. Жирэмсэн болон амаржсаны амралт эдэлсний дараа хүүхдээ нэг нас хүртэл асрах чөлөөтэй байгаа эхчүүдийг зөвхөн хүүхдийг нь нэг нас хүрсэн тохиолдолд урьд ажилд нь эргүүлэн авч ажиллуулна” гэсэн заалт тусган хэрэгжүүлж байсан Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрт энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлтэй зөрчилдөж эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг хязгаарлаж байна гэж үзэн “Эхчүүдийг хамгаалах тухай” Олон улсын хөдөлмөрийн 103 дугаар Конвенци, хөдөлмөрийн болон бусад хуулийн холбогдох заалтад нийцүүлэн даруй өөрчилж, хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

#### **2.1.4.4. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрхийн байдал**

Уул уурхайн салбарт хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрхийн төлөв байдлыг Хүүхдийн эрхийн тухай Конвенци, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай ОУХБ-ын 182 дугаар Конвенц болон хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбон судлахад дээрх албан салбарт хүүхдийг үндсэндээ ажиллуулахгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Зөвхөн Баянхонгор аймгийн Дөвөнтийн нуруунд “Монгол Болгаргео” УҮГ-ын Жаргалантын уурхайн туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа “Тулгажаргалант” ХХК-ны Өвөр Жаргалантын уурхайд нийслэлээс очсон “Номун далай” цогцолборын 10-р ангийн сурагч 17 настай “Ц” түр ажиллаж байсныг эс

тооцвол судалгаанд хамрагдсан уул, уурхайн үйлдвэрүүдэд насанд хүрээгүй хүүхэд ажиллуулсан зөрчил бүртгэгдээгүй юм.

Харин албан бус салбар болох гар аргаар алт, нүүрс, жонш олборлогсдын дотор 18 насанд хүрээгүй хүүхэд цөөнгүй ажилладаг болох нь судалгаагаар нотлогдсон юм.

### **2.1.5. Ялгаварлан гадуурхах хандлага, албадан хөдөлмөрийн тухайд**

**2.1.5.1.** Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно” гэсэн заалт болон хөдөлмөр эрхлэлтэнд ялгаварлан гадуурхахгүй байх тухай ОУХБ-ын 1958 оны 111 дүгээр Конвенц болон 111 дүгээр зөвлөмжийн хэрэгжилттэй холбон дээрх уул уурхайн компаниудад судалгаа хийсэн юм.


“Алтан Дорнод монгол”, “Монгол Болгаргео”, “Эрэл” зэрэг томоохон уурхайтай компаниудын ажиллагсдын дунд явуулсан санал асуулгын дүн болон зарим уурхайд мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн дотоод журмын холбогдох зүйл, заалтаас үзэхэд ажилтныг хөдөлмөрийн хүрээнд ялгаварлах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай дотоод журмандаа: 5.2-д “Сонгон шалгаруулалтад дараах шалгуурыг үндэслэнэ” гээд 5.4, 5.5-д: “Үнэнч шударга, ажилчид 18-35 настай, инженер техникийн ажилтан 45 хүртэл настай ... ” гэж заасныг хүнийг насаар ялгаварлан гадуурхаж буй нэг хэлбэр гэж үзэх үндэстэй байна.

Түүнчлэн “Алтан Дорнод монгол” ХХК-д ижил хөдөлмөр эрхэлж байгаа монгол, орос ажилчдын болон эрэгтэй, эмэгтэй ажилтны цалин харилцан адилгүй байдаг, харьцангуй цалин багатай ажилд монгол иргэд гол төлөв ажилладаг талаар зарим ажилчдаас тавьсан санал хүсэлт болон судалгаанд хамрагдсан ажиллагсдын 23.6 хувь нь хөдөлмөрлөх явцдаа ялгаварлан гадуурхах ямар нэгэн хэлбэрт өртсөн гэж хариулсан зэрэг нь цаашид гадаадын хөрөнгө оруулалттай буюу хамтарсан алтны үйлдвэр, хувийн хэвшлийн зарим

уурхайд хөдөлмөрийн хүрээнд ялгаварлах асуудал гарахыг үгүйсгэх аргагүй байна. Ер нь “Алтан дорнод Монгол” ХХК-д орос, монгол ажилтан ижил хөдөлмөр эрхэлж байхад цалинг ялгавартай тогтоосныг энэ тайлангийн 2.4.1-д тодорхой дурьдсан болно.

Судалгааны явцад санал асуулгад оролцогсдоос ажлын байран дээр янз бүрийн байдлаар ялгаварлах явдал цөөнгүй тохиолддог гэж хариулжээ. Тухайлбал: Санал асуулгад оролцогсдын 23.6% нь хөдөлмөрлөх явцад ямар нэг байдлаар ялгаварладаг гэж хариулсан байна. Үүнийг уурхайн компаниар авч үзэхэд “Мон-Болгар гео”, “Алтан дорнод-Монгол”, “Эрэл” ХХК-ны алтны уурхайд хамгийн их ажиглагдаж байна. (Зураг 2.1.7–ийг үз)

Зураг 2.1.7. Ялгаварлан гадуурхал\* уурхайн компаниар



Асуулга судалгаагаар ажиллагсдад ижил хөдөлмөрт ижил цалин хөлс болон шагнал урамшил олгодоггүй, тэрчлэн нас, үндэс угсаа зэргээр ялгаварлан гадуурхах хэлбэрүүд хамгийн их тохиолдож байна. Тухайлбал: “Мон-Болгар Гео”, “Одод”, “Алтан Дорнод Монгол”, “Мон-Дулаан” зэрэг 4 компаний нийт 9 ажилтанд адил хэмжээний ажил хийлгээд бага цалин олгодог, “Мон-Болгар Гео”, “Эрэл”, “Алтан Дорнод Монгол” зэрэг 4 компанийн нийт 5 ажилтанг нас, үндэс угсаагаар ялгаварладаг, мөн дээрх 3 компанийн нийт 5 ажилтанд шагнал урамшил олгодоггүй зэрэг хэлбэрээр ялгаварладаг байна. (Хүснэгт 2.1.1-ийг үз)

Хүснэгт 2.1.1. Ялгаварлан гадуурхаж буй хэлбэрүүдийг байгууллагаар авч үзвэл:

Уурхайн компаниуд	Ялгаварладаг		Үүнээс:						
	тоо	Хувь	хийлгээд цалинг бага олгодог	Шагнал урамшил олгодоггүй	Байнга хүнд хүчир ажил хийлгэдэг	Элдвээр дарамталдаг	Албан тушаал ахиулдаггүй	Бусад (нас, үндэс угсаагаар)	
Т энд Ч	1	20,0%						1	
Мон-Болгар Гео	9	39,1%	2	2					
Мон-Дулаан трейд	1	20,0%	1						
Тал булаг	3	27,3%							
Одод	3	33,3%	1		1			2	
Эрэл	5	50,0%		1					
Мөнх-Оргил	1	11,1%						1	
Шижир алт	1	7,1%							
Алтандорнод-Монгол	6	42,9%	5	2	1	1	4	1	
			9	5	2	1	4	5	
<b>Бүгд</b>	<b>26</b>	<b>25,4%</b>	<b>20,9%</b>	<b>11,6%</b>	<b>4,7%</b>	<b>2,3%</b>	<b>9,3%</b>	<b>11,6%</b>	

**2.1.5.2.** Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.14-д **“албадан хөдөлмөр”** гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтанд оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил үүргийг хэлнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь албадан хөдөлмөрийн шинжийг өргөн утгаар болон зарим талаар нарийвчлан тодорхойлсон хэдий ч дээрх шинжийг агуулаагүй бол хэн ч хүнээр шаардаж ажил, үүрэг гүйцэтгүүлэх замаар албадан хөдөлмөр хийлгэж болох мэтээр ойлгогдож байгаа бөгөөд энэ нь зөвхөн “Албадан хөдөлмөрийг болон заавал хийлгэх хөдөлмөрийг устгах тухай” ОУХБ-ын 1957 оны 105 дугаар Конвенцийн заалтыг удирдлага болгосон байна. Гэтэл “Албадан ба заавал хийлгэх хөдөлмөрийн тухай” ОУХБ-ын 1930 оны 29 дүгээр Конвенцид **“албадан ба заавал хийлгэх хөдөлмөр гэдэг нэр томъёо нь ямар нэг шийтгэл ногдуулах зорилгоор аль нэг иргэнээс гүйцэтгэхийг шаардсан ажил, үйлчилгээг хэлнэ, гэхдээ уг иргэн нь өөрөө сайн дураар гүйцэтгэхийг санал болгоогүй байна.”** гэж заасныг харгалзан үзээгүй учир албадан хөдөлмөр гэдгийг төгс тодорхойлж чадаагүй байна.

Шалгалт судалгаанд хамрагдсан байгууллагуудад ажилтныг албадан хөдөлмөр хийлгэсэн буюу зориудаар хийлгэж байгаа тохиолдол илт байгаагүй ч зарим алтны уурхай, гар аргаар алт олборлогчдын хооронд талбай ашиглалтаас үүссэн зөрчлийн улмаас албадан хөдөлмөр хийлгэх болон ямар нэгэн хэлбэрээр дарамтлах байдлаар хүний эрхийг зөрчсөн тохиолдол нэг бус удаа гардаг болох нь Өвөрхангай аймгийн Уянга сумын Засаг даргын танилцуулга, 2003 оны 7-р сарын 15-ны өдрийн 01-220 тоот албан бичиг, Өлтийн уурхайн ашиглалтын талбай орчмоос хувиараа алт олборлогчдоос авсан асуумжийн дүнгээс харахад ерөнхийдөө ойлгогдоно. (Засаг даргын албан тоот, асуумжийн дүнг хавсаргав)

Асуумжид оролцогчдын дийлэнх нь “Эрэл” ХХК-ны алтны уурхайн зарим ажилтан ялангуяа хамгаалагч, цагдаа нар талбайгаас хөөх, ажлын багаж хэрэгсэл хураах, сүрдүүлэх, баривчлах, хүчээр өөр ажил хийлгэх зэргээр дарамталдаг, зарим үед эрэгтэйчүүдийг зодох тохиолдол ч гардаг гэж хариулсан байна.

Түүнчлэн эмэгтэйчүүдээр өрөө цэвэрлүүлэх, хувцсаа угаалгах, хог түүлгэх, эрэгтэйчүүдээр мод хөрөөдүүлж хагалуулах, нүх ухуулах, дугуй нөхүүлж автомашин засуулах хүртэл ажил хийлгэдэг, гар аргаар алт олборлогчдын дунд бусдыг сүрдүүлж олсон алтыг нь хямд үнээр авах буюу булаах зэргээр дарамталдаг хэсэг бүлэг хүмүүс ч байдаг тухай нэлээд баримттай хариулсан байдаг.

## **2.2. Албан бус салбарт гар аргаар ашигт малтмал олборлогсдын эрхийн төлөв байдал**

### **2.2.1. Албан бус салбарт гар аргаар ашигт малтмал олборлогсдын байршил, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн төлөв байдал**

Энэхүү судалгааг Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут сум, Өвөрхангай аймгийн Уянга сум, Төв аймгийн Заамар сум, Нийслэлийн Налайх дүүрэг, Дорноговь аймгийн Айраг сумдад албан бус салбарт гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэд, тэдний ажиллаж буй зарим сумдын удирдлага, холбогдох ажилтнуудтай уулзаж ярилцан санал солилцох, ажлын байрны нөхцөл байдлыг танилцах замаар явуулав. Түүнчлэн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Орчин-эрүүл мэнд судлалын төвөөс Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутагт хувиараа алт олборлогсдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын байдалд 2002 онд явуулсан судалгааны тайлан, МУИС-ийн Хүн ам зүйн сургалт судалгааны төвөөс алтны уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн байдлын талаарх судалгааг 2002 онд явуулсан тайлан, бусад холбогдох байгууллагын шалгаж, танилцаж судалсан баримт бичиг, илтгэлүүд зэрэг баримт материалтай танилцав.

#### **2.2.1.1. Гар аргаар алт олборлогсдын байршил**

Гар аргаар алт олборлогсод Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Говь-Алтай, Сэлэнгэ, Төв, Увс зэрэг аймгуудад ихэвчлэн байгаа бөгөөд бүрэн бус мэдээгээр 30.6-42.1 мян. хүн байдаг гэсэн мэдээ бий<sup>6</sup>.

Мөн тэрчлэн Налайх дүүрэгт албан бус салбарын чиглэлээр хувиараа нүүрс олборлогсод цөөнгүй, ойролцоогоор 230-300 хүн, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг сумдад жонш хувиараа олборлогсод 500-800 хүн ажилладаг байна.

Хамгийн олон хувиараа алт олборлогсод ажилладаг аймаг, сумд гэвэл: Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут сумдын орчимд 10 гаруй мянга, Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн алтны уурхайн орчимд 5000-

---

<sup>6</sup> “Ашигт малтмал гар аргаар олборлолт, ажил олгогч эздийн байгууллагын үүрэг, оролцоо” сэдэвт семинарын материалаас

6000 хүн, Төв аймгийн Заамар суманд 2500 орчим хүн тус тус гар аргаар алт олборлодог байна.

Тус комиссоос судалгаа явуулах үеэр Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг “Аман-Ус” гэдэг газарт 40 гаруй иргэд, мөн сумын нутаг “Улаан булаг” хэмээх газарт 30 гаруй өрхийн 100 шахам хүн, Бөмбөгөр сумын нутаг дахь “Адгийн худаг” хэмээх газарт 100 гаруй өрхийн 1000 орчим хүн, мөн сумын “Ар гашуун ус” гэдэг газарт 30 гаруй өрхийн 120 гаруй хүн, Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн алтны уурхайн орчим 800 гаруй өрхийн 4000 гаруй хүн тус тус гар аргаар шороон ордоос алт олборлож байсан юм.

Тэрчлэн Дорноговь аймгийн Айраг сумын хэд хэдэн газраас хувиараа гар аргаар жонш олборлож байгаа 60 гаруй иргэдтэй уулзаж ярилцав.

Налайхын нүүрсний уурхайд хувиараа нүүрс олборлож буй 200 гаруй хүнтэй уулзаж ярилцан 22 хүнээс тус тус санал асуулга авлаа.

### **2.2.1.2. Гар аргаар алт олборлогсдын нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн байдал**

Өвөрхангай, Баянхонгор аймгийн доорх газруудад алт олборлож буй иргэдээс бичгээр санал асуулга авсан. Үүнд:


Судалгаа авсан газар	Судалгаанд оролцсон хүн	
	Тоо	%
Баянхонгор		
Адгийн худаг	18	25,4
Гашуун ус	8	11,3
Улаанбулаг	17	23,9
Өвөрхангай		
Өлтийн ам	28	39,4
<b>Бүгд</b>	<b>71</b>	<b>100,0</b>

Судалгаанд Баянхонгор, Өвөрхангай аймгийн нийт 71 иргэд оролцсон бөгөөд түүврийн төлөөлөх чадвар, мэдээллийн үнэн бодитой байх магадлал хангалттай гэж үзлээ. Санал асуулганд хамрагдагсдын боловсролын түвшинг авч үзвэл: дээд болон тусгай дунд боловсролтой иргэд 7.5%, бүрэн ба бүрэн бус

дунд боловсролтой иргэд 59.7%, бага болон огт боловсролгүй иргэд 32.8% нь байна.

Алт хувиараа гар аргаар олборлогсад явуулын байдлаар ажилладаг бөгөөд тэдгээр иргэдийн 23.9% нь сумын төвөөс, 22.5% нь аймгийн төвөөс, 45.1% нь нийслэл, дүүргээс ирэгсэд байх ба 2.8% нь тогтмол суух орон гэргүй “тэнэмэл” хүмүүс байдаг байна. Тэдний 76.1% нь 4 ба түүнээс дээш ам бүл тэжээдэг бөгөөд өрхийн орлогынхоо 74.6%-ийг алт олборлолтоор бүрдүүлдэг байна. (Зураг 2.2.1.-ийг үз)

Зураг 2.2.1. Гар аргаар алт олборлогсодын өрхийн орлогын эх үүсвэр\* хувиар



Та алт олборлосноор өрхийн амьдралд оруулж буй хувь нэмэр? гэсэн асуултанд дээрх санал асуулгад оролцогсдын 53.7% нь өрхийн нийт орлогын дийлэнхийг алт олборлолтоор оруулж байна гэж хариулжээ.

Дээрх санал асуулгад хамрагдсан хүмүүсийн 91.5% нь болж байгаа гар аргаар алт олборлогсад нь аймаг, сумын төв, хөдөөнөөс ирж буй малчид байх бөгөөд тэд нар малаа зуданд үхүүлснээр амьжиргааны эх үүсвэргүй болж, ажил олдохгүйгээс алт олборлох ажилд татагдан оржээ.


ГAAO нь алт олборлолтоор сард доод тал нь 10,000 төгрөг, дээд тал нь 240,000 төгрөг, дунджаар 55 679.2 төгрөгийн орлого олж байна. Судалгаанд оролцсон нийт хүний 19.7% нь өрхийн амьжиргаандаа 30,000 төгрөг буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний, 15.5% нь түүнээс бага орлого тус тус оруулдаг. (Хүснэгт 2.2.2-ыг үз)

Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогч өрхийн нэг гишүүнд оногдож буй сарын орлогын түвшингэ үзэхэд 39.6% нь өрхийн амьжиргааны баталгаажих түвшин<sup>7</sup>гээс доогуур орлоготой буюу ядуучууд байгаа ба 47.2% нь нэн ядуу амьдралтай иргэд байна. (Зураг 2.2.2-ыг үз)

### Хүснэгт 2.2.2. Алт олборлолтоор олж буй сарын орлого

Орлого* төгрөгөөр	Хүний тоо	Хувь
30 000>	11	15,5
30 000	14	19,7
40 000-50 000	11	15,5
60 000-90 000	10	14,1
100 000<	7	9,9
Бүгд	53	74,6
Хариулаагүй	18	25,4
<b>Дүн</b>	<b>71</b>	<b>100,0</b>

### Зураг 2.2.2. Өрхийн нэг гишүүнд оногдож буй сарын орлого



### 2.2.2. Гар аргаар ашигт малтмал хувиараа олборлох болсон шалтгаан, үндэслэл

Албан бус салбарт ашигт малтмал олборлох болсон доорх үндэслэл, шалтгаан байгаа нь судалгаанаас харагдаж байна.

- Хувиараа алт олборлогсдын дийлэнх болж байгаа малчид сүүлийн хэдэн жилийн ган зудын уршгаар малгүй болж улмаар нэн ядуу, ядуу иргэдийн эгнээнд шилжиж амьдралын эх үүсвэргүй болсон;
- Байгаль, цаг уурын бэрхшээл болон эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж газар тариалангийн ажил зарим хэсэгт суларч зогсонги байдалд хүрсэн;
- Улсын үйлдвэр, аж ахуйн газрууд хувьчлагдсан болон тэдгээрт орон тоог багасгаж, цомтгол хийгдсэн, зарим үйлдвэр, аж ахуйн газрууд хаагдсан зэргээс төв суурин газрын ажиллагсад бөөнөөр ажилгүй болсон;
- Төсөвт байгууллагын болон хувийн хэвшлийн байгууллагын зарим ажиллагсдын цалин, хөлс нь амьжиргааны өртгийн өсөлтийг гүйцэхгүй буюу өдөр тутмын наад захын хэрэгцээг хангахгүй болсны улмаас ажилтай боловч ядуувтар хүмүүс олширсон;

<sup>7</sup> Өрхийн амьжиргааны баталгаажих доод түвшин хангайн бүсэд 19,000 төгрөг байдаг

■ Төвөөс алслагдсан орон нутагт зах зээлээс хол, дэд бүтэц хөгжөөгүй, төвийн бүсийг бодвол барааны үнэ харьцангуй өндөр, ажлын байр хомс зэрэг бэрхшээлээс шалтгаалан төв рүү чиглэсэн “их нүүдэл” шилжилт хөдөлгөөн бөөгнөрөл бий болсноос нэг хэсэг нь гар аргаар хувиараа ашигт малтмал олборлоход хүрсэн;

■ Хөдөө зарим айл, өрхүүд болон төв, суурингийн орлого багатай иргэд их дээд сургуульд сурдаг оюутан хүүхдийнхээ сургалтын болон унаа, байр, бусад шаардлагатай зардлыг төлөх зайлшгүй хэрэгцээ байдгаас албан бусаар ашигт малтмал олборлох замаар мөнгө хуримтлуулах болсон;

■ Зах зээлийн нөхцөл, эрэлт хэрэгцээ нь хүмүүсийн сэтгэлгээг өөрчилж, хувиараа хөдөлмөр эрхлэх, өөрөө орлого олох, бусдаас хараат бус байх хүсэл эрмэлзэлтэй нэг хэсэг хүмүүс бий болсон;

■ Үүнээс гадна манай улсын ихэнх аймгууд ялангуяа төвийн, зүүн болон хангайн бүсийн аймгуудад ашигт малтмалын орд газар ихээхэн нээгдэж, түүнийг ашигладаг уурхайн компаниуд олноор ажиллах болсон байна.

Эдгээр нь гар аргаар буюу өөрт буй боломжоороо хувиараа ашигт малтмал олборлох зайлшгүй нөхцөлийг бүрдүүлж байна.

### **2.2.3. Албан бус салбарт гар аргаар ашигт малтмал олборлогсдын хөдөлмөрлөх эрх болон бусад эрхийн төлөв байдал**

#### **2.2.3.1. Ажил, амралтын горим**

Зөвхөн гар аргаар алт олборлогсдын ихэнх хувь буюу нийт судалгаанд хамрагдсан хүн амын 78.9% нь өдөрт 8-аас дээш цаг ажилладаг. Үүнийг хоногт ажилласан цагаар тооцвол судалгаанд хамрагдсан нийт ГААО-ын 52.1% нь хоногт 8-аас<sup>8</sup> илүү цаг ажилладаг, тэдний 69.0% нь долоо хоногийн амралтын өдрүүдэд амардаггүй бөгөөд 83.3% нь нөхөн амардаггүй ажээ.

Гар аргаар ашигт малтмал олборлогсдын хувьд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг Хөдөлмөрийн тухай хуулийн заалт, шаардлагыг хэрэглэх боломжгүй юм.

---

<sup>8</sup> 8 цаг - Монгол улсын Хөдөлмөрийн хуулиар хоногт нормчилсон ажлын цаг

Гар аргаар алт олборлогсад дулааны улиралд хоёр нарны хооронд буюу өглөөнөөс орой бүрэнхий болтол ажилладаг байна. Өөрөөр хэлбэл энд илүү цагаар ажилласныг нөхөн амрах буюу амралт, баяр, ёслол, долоо хоногийн амралтын өдөр амрах тухай ойлголт бараг үгүй юм байна.

### **2.2.3.2. Гар аргаар алт олборлогсад(ГААО)-ын ажлын болон ахуй амьдралын орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдал**

Гар аргаар алтны ил ордоос алт олборлох үйл ажиллагаа нь технологи ажиллагаа, ажлын байрны нөхцөлийн хувьд дараахь онцлогуудтай байна. Үүнд:

■ Алтны ил уурхай нь хээрийн нөхцөлд задгай агаарт явагддаг тул улирал, цаг уурын тааламжгүй нөлөөлөлд байнга өртөгдөх онцлогтой бөгөөд ажлын байрны хүнд нөхцөлд тооцогдох бүрэн боломжтой байна.

■ Технологийн нэг гол дамжлага бол олборлосон алтаа усаар угааж, тунгааж ялгах явдал байдаг тул Баянхонгор аймаг мэтийн ил задгай ус ховор газарт усаа холоос зөөж хэрэглэх явдал цөөнгүй гардаг. Нөгөөтэйгүүр, алт угаах үйл ажиллагаа усан орчинд явагддагтай холбоотой хүйтэн сэрүүний улиралд чийг авч амархан даарч хөрөх хандлага ихээр тохиолддоно.



*Усанд алтаа угааж байгаа нь . . .*

■ Хувиараа гар аргаар алт олборлогч нарт техник хэрэгсэл байдаггүйгээс гарын доорхи багажаар газар малтах, нүх ухах, шороо шигших, шороо зөөх, ус зөөх, чулуу бутлах зэргээр нэг хүн бараг 4-6 төрлийн биеийн хүчний хүнд хүчир ажлуудыг хийдэг байна.



ГAAO-ын хэрэглэдэг багажууд

📖 Хувиараа гар аргаар алт олборлогч нарт албан ёсоор алт олборлох зөвшөөрөл олгодоггүй тул тэдэнд албан ёсны зөвшөөрөлтэй газар байдаггүйгээс аль алтны гарц ихтэй газар буюу аль эсвэл уурхайн компани эзэмшил газарт хулгайгаар алт олборлодог.

Мөн түүнчлэн ГAAO нарт тавих хараа хяналт байдаггүйгээс алтны гарцаас хамааран дур мэдэн газрыг ухаж, нүхэлж газар доор алт олборлох үйл ажиллагаагаа явуулдаг байна. Ингэж газар доор ажиллах нь 1) цэвэр агаар дутагдах, хийн мандлын агаарын их даралт нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх 2) ялангуяа шороон ордтой газар доогуур ямар ч хамгаалалт бэхэлгээ хийлгүйгээр орж ажилласнаар шороонд дарагдаж осолдох явдал цөөнгүй гардаг байна. Уурхайн эдэлбэр газар хиймэл нуурын далантай ойролцоо алт олборлож буй ГAAO далангийн шороог ухаж нүхэлснээс далан задарч хүчтэй ус олгойдон улмаар шороонд дарагдаж гэмтэж нас барах тохиолдол ч бас цөөнгүй гардаг байна.

Баянхонгор аймагт сүүлийн 2 жилд алт олборлож байгаад 32 хүн шороонд дарагдаж, үүнээс 8 хүн нас барсан, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт сүүлийн 5 жилд алт олборлох үйл ажиллагаатай холбоотойгоор 35 хүн нас барж, 12 хүн тахир дутуу болсон байна.

Төв аймгийн Заамар сумын нутагт гар аргаар алт олборлогчдоос зөвхөн сүүлийн 2 жилд 15 хүн шороонд дарагдаж нас баржээ.

Үүнээс үзэхэд албан бус салбарт гар аргаар алт олборлох ажиллагаанд хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа туйлын хангалтгүй, хүн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах эрх ноцтой зөрчигдөж байна.

Өмнөх жилүүдэд алт олборлох үйл ажиллагаанд алтыг бариулах зорилгоор мөнгөн усыг ихээр хэрэглэдэг хандлага байсан талаар бусад судлаачдын судалгаагаар тогтоогдож байсан бол энэ жилээс бидний судалсан газруудад мөнгөн усыг хэрэглэх явдал эрс багассан байлаа. Гэвч судалгаанд оролцсон ГААО-ын 11.2% нь мөнгөн усыг алт бариулах шаардлагаар хэрэглэдэг бөгөөд тэдгээрийн ихэнх (87.5%) хувь нь мөнгөн усаа өөрсдөө олдог байна. (Хүснэгт 2.2.4.-ийг үз)

Мөнгөн ус нь аюулын зэргээр химийн маш их хортой бодисын ангилалд багтдаг бөгөөд химийн хортой нөхцөлд ажилласнаар хүн мөнгөн усны архаг болон хурц хордлогод орж, улмаар бүх эрхтэн системийг нь гэмтээх аюултай байдаг.

		Хүний тоо	Хувь	Хувь <sup>a</sup>
Хэрэглэдэг	Хүнээс худалдаж авдаг	1	1,4	12,5
	Өөрөө олдог	7	9,9	87,5
	Бүгд	8	11,2	100,0
Хэрэглэдэггүй		63	88,8	
Дүн		71	100,0	

<sup>a</sup> Мөнгөн ус хэрэглэдэг ГААО-ын хувь

Үүнээс үзэхэд комиссын энэхүү судалгаанд хамрагдсан иргэдийн 11.2% нь мөнгөн ус хэрэглэдэг байна.

Эдгээрээс гадна алтны үндсэн орд бүхий Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 6 сумын уурхайд гар аргаар хувиараа алт олборлодог иргэд, мухлагийн зарим худалдагч, Бороо голын орчмоос түүх, таньдаг хүмүүстэй захиж авах зэргээр мөнгөн усыг олж авч, алт бариулахдаа хэрэглэдэг байна. Тэд мөнгөн усаар алт бариулахдаа байршлын хувьд 63.0% нь гэртээ, 20.0% гаруй нь гэрийнхээ гадна,

үлдсэн 20% хүрэхгүй нь тусгай байранд, уурхай болон гол дээр гэм мэт газарт алтаа мөнгөн усаар бариулдаг байна<sup>10</sup>.

Ингэж технологийн бус, буруу аргаар мөнгөн усаар алт бариулж байгаагийн уршгаар алтны үндсэн ордод гар аргаар алт олборлодог 341 хүнээс түүвэр судалгаа болон дээж авч шинжилгээ хийхэд эдгээрт оролцогсдын 17% буюу 59 хүнд мөнгөн усны архаг хордлогын шинж тэмдэг илэрсний 17 нь хүүхэд байсны 48%-д нь мөнгөн усны архаг хордлогын шинж тэмдэг лабораторийн шинжилгээгээр давхар батлагдсан байна. Ер нь судалгаанд хамрагдагсдын ихэнх нь буюу **67.9% нь мөнгөн усаар бариулж**, ууршуулан хэрэглэж байжээ. Үүнээс хүүхдийн 32.8% нь, насанд хүрэгсдийн 852% нь мөнгөн усаар алт бариулж байсан байна<sup>10</sup>.

Алт олборлох үйл ажиллагаанд нэгэнт ус зайлшгүй хэрэглэгддэг тул усны олдоцоос хамаарч улирлын чанартайгаар зуны улиралд гар аргаар алт олборлохоор газар газраас хүмүүс ихээр ирж, нэг газар олноор бөөгнөрөн суурьшлын орчныг үүсгэдэг. Энэ нь тэдгээр хүн амын эрүүл мэндэд дараахь сөрөг үр дагавруудыг авчирч байна. Үүнд:

 ГААО алт олборлох үйл ажиллагаатай холбоотой өөр өөр газраас олноор ирж суурьшиж буй явдал нь янз бүрийн халдварт өвчний үүсгэгчийг нэгээс нөгөөд зөөвөрлөж, улмаар тухайн орон нутагт гарч байгаагүй халдварт өвчин эмгэг шинээр гарах шалтгаан болдог. Ингэснээр ГААО-ын дунд нийт халдварт өвчин ихсэхэд ихээхэн нөлөө үзүүлж болзошгүй байдаг.

 Зуны улиралд ялангуяа усны олдоц ховор газар ариун цэврийн байдал туйлийн муу сахидгаас гэдэсний халдварт өвчин ихсэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг.

 Нутгийн хүмүүсийн ярьж байгаагаар зуны улиралд нэг газар ойролцоогоор 3000 гаруй хүн ам цугларч, суурьшиж бараг сум, түүнээс том суурьшлын орчныг үүсгэдэг байна. Гэтэл дээрх хүн ам нь албан ёсны бүртгэлгүй байдгаас захиргааны ямар ч хараа хяналт байдаггүй тул

---

<sup>10</sup> НЭМ-ийн Хүрээлэн Н.Сайжаа “Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад хувиараа алт олборлож буй хүмүүсийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын байдал” судалгааны тайлангаас

суурьшлын орчин тойрныг төдийгүй, байгаль орчныг ихээр бохирдуулж байна.

**Баримт:** Улаанбулгийн орчимд зуны цагт ГААО-гч бараг 3000 гаруй хүн ам ирж суурьшдаг. Тэд жорлон байхгүйгээс гэрийнхээ гадаа бие засдаг бөгөөд тэнд байхад баас, шээсний их эвгүй үнэр ханхалсан, маш бохир заваан байдаг.

Баянхонгор аймгийн уул уурхайн байцаагч Ц.Болорчимэг



Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн дээд амны “Персийн булан”-ийн ГААО

Мөн түүгээр ч үл барам дээрх суурьшлын хүн ам нь бие засах газар, бохир ус, хог хаягдлаа хаяж, зайлуулах газар байдаггүйгээс өөрсдийн амьдарч буй орчиндоо бие засах, бохир ус, хог хаягдлаар суурьшлын орчныг маш ихээр бохирдуулж, улмаар тэнд амьдарч буй хүн ам нь ахуйн хавьтлаар янз бүрийн халдварт өвчнөөр өвчлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

ГААО ямар ч зохион байгуулалт, хараа хяналтгүйгээр газрыг сэндийчлэн олон тооны гүнзгий нүх ухаж, түүнийгээ буцааж булж сэргээлгүй орхисноос өөрсдийн болон бусад хүн амьтны бие эрхтэнд гэмтэл учруулах, цаашилбал амь нас хохирч болох нөхцөлийг бүрдүүлж байна.



ГААО-ын ухаж орхисон нүхнүүд

Мөн түүнчлэн ГААО, ялангуяа Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн аманд гар аргаар алт олборлож буй хүмүүс Онгийн голын усанд алтаа шууд угаадаг болох нь судалгаагаар илэрч байсан бөгөөд энэ нь өөрсдийн болон сумын оршин суугчдын ундны усны эх үүсвэрийг бохирдуулж байна.




Онгийн голын усанд алтаа угааж байгаа нь . . .

### **2.2.3.3. Гар аргаар алт олборлогсдын эрүүл мэндийн байдал**

ГААО-ын эрүүл мэндийн байдлыг судалж үзэхэд судалгаанд хамрагдагсдын 34 буюу 48.0% нь ямар нэг өвчин эмгэгтэй гэж хариулсан бол 18.2% нь мэдэхгүй, эмнэлэгт үзүүлж байгаагүй, харин 33.8% нь өөрийгөө эрүүл гэж хариулжээ. Уг судалгаагаар тэдгээр хувиараа алт олборлогсдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулаагүй тул дээрх эрүүл буюу өөрийнхөө эрүүл мэндийн байдлыг мэдэхгүй гэсэн бусад хүмүүсийг үл тооцвол судалгаанд хамрагдсан нийт хүн амын дор хаяж тал хувь нь ямар нэг өвчин эмгэгтэй байгаа нь тогтоогдож байна. (Зураг 2.2.3-ыг үз)

Дээрх өвчлөлийн байдлыг нарийвчлан судалж үзэхэд бөөр болон шээс, бэлгийн замын өвчлөл хамгийн өндөр буюу нийт өвчний 68 тохиолдлын дотор 32.3%-ийг эзэлж, дараагийн байрыг үе мөчний өвчин-23.5%, нүд, чих, хамар хоолойн өвчин-16.1%, зүрх судас, мэдрэлийн ядаргаа-8.8% тус тус эзэлж байна. (Зураг 2.2.4-ийг үз)

Зураг 2.2.3. ГААО-ын эрүүл мэндийн байдал



Зураг 2.2.4. ГААО-ын өвчлөлийн байдал.




Өвчтэй хүмүүсийн ихэнх нь буюу 65.6% (21 тохиолдол) нь өөрийн өвчний шалтгааныг уг ажилтай холбоотой, харин үлдсэн 34.4% нь уг ажлыг хийхээс өмнө болон ахуйн ослоор гэмтсэн гэж хариулсан байна. (Зураг 2.2.5-ыг үз)

Үүнийг тэдний дунд зонхилон тохиолдож байгаа 3 нэрийн өвчнөөр авч үзвэл:


Уг ажлыг хийхээс өмнө өвчилсөн хүмүүстэй харьцуулахад бөөр, шээсний замын өвчтэй хүний тоо 3.2 дахин, үе мөчний өвчтэй хүний тоо 3 дахин, нүд, чих, хамар, хоолойн өвчтэй хүний тоо 3.5 дахин тус тус их байна. (Хүснэгт 2.2.5-ыг үз)

Энэ нь тэдний ажлын байрны нөхцөлтэй холбоотой задгай агаарт, шууд газар дээр суух, цаг уурын хүйтэн халуун ямар ч нөхцөлд ус, чийгтэй орчинд цаг наргүй ажиллах, хүнд шороо, ус зэргийг байнга өргөж, зөөх зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр даарч, хөрөх, ханиад, томуу хүрэх, хэт ачаалалтай ажилласнаар дээрх өвчнүүдээр өвчлөх хандлага их гардаг байна.

Зураг 2.2.5. Өвчний шалтгаан



Зураг 2.2.6. Өвчлөлийн байдал, ажилласан жилээр



Хүснэгт 2.2.5. Өвчний шалтгаан, зонхилон тохиолдож буй өвчнөөр

Өвчний шалтгаан	Бөөр, шээс		Үе мөч		Нүд, чих, хамар, хоолой	
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь
Уг ажлыг хийхээс өмнө	5	23.8	4	25.0	2	20.0
Уг ажилтай холбоотой	16	76.2	12	75.0	7	70.0
Ахуйн осол					1	10.0
Бүгд	14	100	12	100	6	100

Өвчлөлийн байдлыг ажилласан жилээр авч үзвэл:


Гар аргаар алт олборлох ажлыг эрхлээд 1 жил болоогүй нийт 21 хүнээс 38.1% нь өвчтэй байхад 1-5 жил ажилласан нийт хүмүүсийн дотор өвчтэй хүний эзлэх хувь 56.4-66.7% болтлоо өссөн байгаа нь тэдгээр ГААО-ын өвчлөлийн байдалд тэдний эрхэлж буй ажил нөлөөлж байгааг баталж байна. (Зураг 2.2.6.-ыг үз)

Судалгаанд хамрагдсан нийт ГААО-ын 50.7% нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын алиныг ч сайн дураараа хийлгээгүй байсан ба харин 8.5% нь эрүүл мэндийн даатгалыг сайн дураараа хийлгэсэн байна.

#### 2.2.3.4. Гар аргаар хувиараа алт болон бусад ашигт малтмал олборлогсдын зарим эрхийн төлөв байдал, тэдэнд тохиолдож буй бэрхшээл, дарамт шахалт

ГААО-ын зарим эрхийн төлөв байдлыг судалж үзэхэд судалгаанд оролцогсдын ихэнх хувь нь хөдөлмөрлөх эрх (44.2%), чөлөөтэй алт олборлох эрх (30.7%) зөрчигддэг хэмээн хариулж байлаа. (Зураг 2.2.7-ыг үз)

Зураг 2.2.7. ГААО-ын дунд зөрчигддэг хүний зарим эрх.



Тэдний хувьд хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломж бодитой нөхцөл бүрдээгүй. Өөрөөр хэлбэл тэдний хувиараа алт болон бусад ашигт малтмал олборлох үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдаж зохицуулах механизм дутагдаж үгүйлэгдэж байна.

Үүнээс болж тэд, тэтгэвэр, тэтгэмж, өвчлөхөд үнэ төлбөргүй эмчлүүлж, эмнэлгийн тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, улмаар сурч боловсрох зэрэг бусад шаадлагатай эрхээ эдэлж чадахгүй байна.



ГАО-гч нэгэн өрхийн амьдарч буй гэрийн дотор, гадна тал

Асуумж судалгаагаар ГАО-ын бичсэн алт олборлох үйл ажиллагаатай холбоотой бэрхшээлүүдийг жагсаавал:


- Ажлын нөхцөл маш хүнд,
- Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл муу,
- Байнга халуунд халж, хүйтэнд хөрч байдаг,
- Ядарч эрүүл мэнд муудаж байна,
- Бидэнд ажлын талбай байдаггүй, өгдөггүй
- Ажлын багаж, хэрэгсэл байдаггүй,
- ГАО-ыг харж үздэггүй, бид эзэнгүйдэж байна,
- Байнга айж зугтаж ажилладаг гэсэн хариулт өгч байлаа.

ГАО-д учирч буй хамгийн том бэрхшээл бол алт олборлох үйл ажиллагаа явуулахад гаднаас байнгын дарамт шахалт үзүүлэх явдал байна. Тухайлбал: нийт судалгаанд хамрагдагсдын 76.1% нь гаднаас ямар нэг дарамт шахалт үзүүлдэг гэж хариулжээ.

Дарамт шахалтыг алтны уурхайн компаниуд, сумын засаг захиргаанаас ихэвчлэн үзүүлдэг бөгөөд мөн түүнчлэн өөр сумаас ирсэн болон хамт хувиараа алт олборлож буй хүмүүс, нутгийн ардууд гаднаас ирж алт олборлож буй хүмүүс г.м. байгууллага, хүмүүсээс ихэвчлэн эзэмшлийн газраа харамлах, газраа булаацалдах, байгаль орчныг хамгаалах зэрэг шалтгааны улмаас дарамт шахалт үзүүлдэг байна.

Алтны уурхайн компани, сумын засаг захиргаанаас доорхи хэлбэрүүдээр дарамт шахалтуудыг үзүүлдэг байна. (Зураг 2.2.8.-ыг үз)

Зураг 2.2.8. Дарамт шахалтын хэлбэрүүд



Судалгаанаас харахад ГААО-д хамгийн их хэрэглэж байгаа дарамт шахалт бол алт олборлож буй газраас хөөх (нийт судалгаанд оролцогсдын 69.0%), ажлын багаж, хэрэгслийг хураах (64.8%), айлган сүрдүүлэх, баривчлах (50.7%) зэрэг арга хэлбэрүүд байна.

Дээрх дарамт шахалтын арга, хэлбэрүүд нь хүний хөдөлмөрлөх, амьд явах, эрүүл байх эрхийг зөрчиж байгаа бөгөөд хүний хамгийн гол эрхийг зөрчиж буй хэлбэр бол зодох бөгөөд нийт судалгаанд оролцогсдын 42.3% нь ийм дарамтанд ямар нэг байдлаар орж байдаг байна. Гол төлөв алтны уурхайн компаниуд өөрсдийн компани хамгаалагч цагдаа нараар зодуулж өөрсдийн эзэмшил газрыг хамгаалдаг байна. Зарим тохиолдолд уурхайн дарга нь өөрөө ч бас энэ ажиллагаанд биечлэн оролцдог талаар ГААО ярьж байлаа.

**Баримт:** Манайх 7-уулаа, урьд мал малладаг байгаад зуданд малаа үхүүлээд одоо хувиараа алт олборлож байна. Нөхөр өвчтэй хэвтэрт байдаг, ганц ажил хийдэг хүү маань өнгөрсөн жил алт олборлож яваад Дөвөнтийн уурхайн дарга Баярхүү болон цагдаа нарт зодуулаад гар нь гэмтээд одоо болтол ажил хийж чадахгүй байгаа.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын иргэн, ГААО-гч Д.Цэнд, 57 настай

ГAAO-оос нутгийн засаг захиргаа алт олборлох үйл ажиллагаатай нь холбоотойгоор хууль бусаар татвар авах (нийт судалгаанд хамрагдагсдын 31.0%) байдлаар мөн дарамт шахалт үзүүлдэг байна.

**Баримт:** Сумын тамгын газраас бидний олборлосон алтнаас сард 3000 төгрөгийн татвар авч байна. Энэ нь ямар ч үндэслэлгүй байдаг.

*Баянхонгор аймгийн Бууцагаан сумын иргэн Хүрэлбаатар*

Дээрх албан газруудаас ГAAO-д дарамт шахалт үзүүлэхээс ГAAO нь алтны илэрц сайтай нэгж талбайгаа болон олборлосон алтаа бусдад булаалгаж дээрэмдүүлдэг байна.

Энэ бүх хүндрэл бэрхшээлүүдтэй холбоотойгоор ГAAO-ын 57.7% нь өөр ажил олдвол уг алт олборлох үйл ажиллагаагаа орхино гэж байсан бол 9.9% нь ойрын 1-2 жил үргэлжлүүлэн хийнэ хэмээн хариулж байв.

#### **2.2.3.5. Хүүхдүүд аюултай, хүнд нөхцөлд ажиллаж, хэрээс хэтэрсэн хүнд ачаа үүрч зөөдөг**

Хүүхдүүд гараар газар ухаж алтны нөөц бүхий шороогоо үүрч зөөж гал болон устай газарт аваачиж усаар угаадаг, зарим газарт 2-6 метр гүнзгий нүх, 1-3 метр заримдаа түүнээс ч илүү урт хонгил гарган ухаж алтны агууламж бүхий шороогоо гарган авч байна. Тэд нар шороо нурах, түүнд дарагдах маш аюултай нөхцөлд ажилладаг. Мөн тогтоосон хэмжээнээс хэтэрсэн хүнд ачаа үүрч зөөж байна. Эрэгтэй хүүхдийн гараар өргөх, зөөх ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ 8-16 кг, эмэгтэй хүүхдийнх 5-10 кг байдаг. Гэтэл эрэгтэй хүүхдүүд хагас шуудай буюу ойролцоогоор 25-40 кг, зарим тохиолдолд 50-60 кг жинтэй шуудай дүүрэн шороог 5-20 метр орчим зайд өргөх, үүрч зөөх ажлыг хийж байна.

ХЭҮК-оос судалгаа хийж байсан 2003 оны 10-р сарын дунд үе цас орж хүйтэрсэн байхад Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг “Адгийн худаг”, “Улаан булаг”, Бөмбөгөр сумын нутаг “Гашуун ус” зэрэг газруудад эцэг, эхтэйгээ хамт ойролцоогоор 30 гаруй хүүхэд ажилаж байсан бөгөөд тэд насанд хүрэгсдийн адил 9<sup>00</sup> - 20<sup>00</sup> цаг хүртэл 8-10 цаг газар ухаж, шороо гарган зөөж, үүрэх, алтны илэрцтэй шороог усанд угаах зэрэг хүнд хүчир ажлыг хийж байв

Тэдгээр хүүхдүүд гол төлөв малчдын (малаа зуданд үхүүлж малгүй болж ядуурсан иргэдийн) хүүхдүүд байсан юм.

**Баримт:** Би ээжтэйгээ газар ухаж шороо зөөж, шороо угааж алт олж амьдардаг, 7-р ангиас сургуулиас гарсан, хүйтэнд хэцүү байдаг.

С.Алтансүх, 16 настай, эр, Баянхонгор аймаг, Галуут сум

Алтны уурхайд ажиллаж буй хүүхдийн ихэнх нь зуны цагт хичээлийн жилийн амралтаараа ажилладаг хэдий ч амьдрал ахуйн нөхцөл байдлаас шалтгаалан хэсэг хүүхэд сургууль завсардаж, сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байна.

Зөвхөн Баянхонгор, Өвөрхангай аймгуудын дээрх нэр бүхий 3-4 сумын нутагт хувиараа гар аргаар алт олборлож буй иргэдийн дотор ерөнхий боловсролын сургуулийн насны 30 гаруй хүүхэд сургууль завсардаж явсан юм.

**Баримт:** Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг “Гашуун ус” хэмээх газарт хувиараа алт олборлож хоёр ихэр хүүхэд 6-р ангиасаа гарч алт олборлоход гэрийнхэндээ тусалж яваа гэж ярьж байв.

15 настай эрэгтэй, Т.Ө. нар, Галуут сум

Энэхүү судалгаанд хамрагдсан ГААО-ын 8.5% нь болж буй насанд хүрээгүй хүүхдүүд алт олборлох үйл ажиллагаанд ихээр татагдан орж байгаа бөгөөд тэдний дунд охидууд дийлэнх (83.3%) хувийг эзэлж байна.

## Гурав. Дүгнэлт, зөвлөмж

### 3.1. Дүгнэлт

Бид уг шалгалт-судалгааны үр дүнд доорхь дүгнэлтэнд хүрлээ. Үүнд:

➤ Ашигт малтмал олборлодог аж ахуйн нэгжүүд үндсэндээ хамтын гэрээгүй ажиллаж байна. Хамтын гэрээг байгуулахад ажил олгогч болон ажилтан, түүний төлөөллийн байгууллага, МҮЭ-үүдийн хорооны хүчин чармайлт, санаачлага дутагдалтай байна.

Хамтын гэрээ байгуулахгүй байх нь ашигт малтмал олборлодог байгууллага, аж ахуйн нэгж, ажилтны хоорондын хөдөлмөрийн харилцаатай холбогдсон олон асуудал (илүү цаг, амралт; баяр ёслолын өдөр ажилласан хөлс, сул зогсолтын нөхөх олговор, шөнийн нэмэгдэл, захиргааны чөлөө олгох гэх мэт) хууль, тогтоомжид зааснаас илүү муу нөхцөлөөр шийдэгдэж, ажилтны хөдөлмөрлөх эрхийг хангах ихээхэн боломжийг алдагдуулж байна.

➤ Хөдөлмөрийн гэрээ, дотоод журмаар хөдөлмөрийн харилцааны үндсэн асуудлыг зохицуулах хандлага томоохон үйлдвэр, уурхайд төлөвшиж байгаа хэдий ч гэрээг ёс төдий, ажил олгогчийн эрх ашигт тохируулан байгуулдаг зөрчил нийтлэг байгаагаас хөдөлмөрийн харилцааны тэнцвэр алдагдан хэт нэг талд үйлчлэх, улмаар хүний хөдөлмөрлөх эрх зөрчигдөх сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Түүнчлэн “Эрэл” ХХК зэрэг зарим компаний алтны уурхайд ажилтныг “Ажил гүйцэтгэх гэрээ”-ээр ажиллуулах хандлага нэмэгдэх төлөвтэй байгаа нь “. . . байнгын ажлын байранд зөвхөн хөдөлмөрийн гэрээгээр хүн авч ажиллуулна . . .” гэсэн Хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг зөрчин улмаар нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх болон ажиллагсдын нийгмийн хамгааллын арга хэмжээг орхигдуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

➤ Хүний хөдөлмөрлөх эрх болон бусад холбогдох хууль, тогтоомжийн талаарх ажил олгогч, ажилтан нарын мэдлэг дутмаг, хууль ёсны ашиг сонирхолоо эвлэлдэн нэгдэж хамгаалах талаар ажиллагсдын өөрсдийнх нь идэвх санаачлага хангалтгүй байна.

➤ Ил аргаар ашигт малтмал олборлодог уурхайнуудын үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалт оновчтой бус, хөдөлмөрийн норм, үнэлгээ боловсронгуй болоогүйгээс ажиллагсад илүү цаг ажиллаж, сул зогсох цалин хөлсөө хугацаанд нь бүрэн авч чадахгүй байх дутагдал нийтлэг байна.

Ялангуяа алтны уурхайнуудад хамтын гэрээгээр ажиллаж буй ажиллагсдын хийснээр цалинждаг буюу сул зогсолтын үед тэднийг амрааж, хээрийн нөхцөлд нүүдэллэн ажилласны нэмэгдлийг бүтэн олгодог гэдгээр халхавчилж тэднийг илүү цаг ажилласан үед хөлс авахгүй байхаар ажилтантай тохирсон гэх шалтгаанаар ажиллагсдад илүү цагийн хөлс олгохгүй хохироодог зөрчил газар авсан байна. Үнэн хэрэгтээ үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалт хангалтгүйгээс сул зогсолт гарч, ажилчид нормоо биелүүлж чадахгүй улмаар илүү цаг ажиллаж, харин цалин хөлсөө нэмэгдүүлэх багагүй боломжоо алдаж байгааг ажил олгогчид тэр бүр ойлгохгүй байна.

➤ Үйлдвэрлэл явуулж буй арга болон ажлын байрны нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах талаар зохиосон ажлын үр дүн харилцан адилгүй байгаагаас ил аргаар ашигт малтмал олборлодог ихэнх уурхайд үйлдвэрлэлийн осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл буурахгүй байна.

➤ Шалгалт-судалгаанд хамрагдсан үйлдвэр, уурхай хүүхэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон ОУХБ-ын Конвенц болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг үндсэндээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Харин гар аргаар ашигт малтмал олборлох ажилд хүүхдүүд сургуулиас завсардан оролцож тоос шороо, мөнгөн усны ууршилттай хэвийн бус, хүнд нөхцөлд ажиллаж байгаа нь “Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, “Өргөх зөөх ачааны дээд хэмжээ” тогтоосон стандартыг зөрчин, “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай” ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар Конвенц, Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалт зөрчигдөж байна.

- Алтны зарим уурхайнууд, хувийн хэвшлийн байгууллагад ажилтны хөдөлмөрлөх явцад нас, хүйс, цалин хөлсөөр ялгаварлах хандлага бий болсон байна.
- Ашигт малтмал олборлох уурхайнууд орон нутгаас авч ажиллуулж байгаа ажиллагсдыг нийгмийн даатгалд хамруулах асуудалд хайнга хандаж байна.
- Ашиглалтын лицензтэй уурхай, гар аргаар ашигт малтмал олборлогсад болон орон нутгийн захиргааны байгууллага буюу иргэдийн хоорондын зохистой түншлэлийг бий болгох боломж, нөхцөлийг судлан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай болсон байна.

Ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хүний хөдөлмөрлөх эрхийг хангах, энэ талаархи ОУХБ-ын конвенц, зөвлөмж болон Монгол улсын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж байгууллага хайнга хандаж байгаа нь ажиллагсдын хөдөлмөрлөх эрх ямар нэг байдлаар зөрчигдөх үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна гэж дүгнэж байна.

Уул уурхайн салбарын мэргэжлийн байгууллага, хяналт шалгалтын байгууллагын ажлын уялдаа холбоо, шалгалтын үр нөлөөг сайжруулахын хамт тэднээс ашигт малтмал олборлох уурхайд бодитой туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлыг өргөжүүлэх шаардлагатай байна.

### **3.2. Зөвлөмж**

#### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, зөвлөмж**

Шалгалт, судалгааны ажлын дүнд үндэслэн ашигт малтмал олборлох салбарт ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

1. Ажиллагсдын хөдөлмөрлөх эрх зүйн шаардлага хангасан орчинг бүрдүүлэх зорилгоор 2004 оны эхний хагас жилд багтаан дор дурдсан ажлыг зохион байгуулах:

а. Уул уурхайн мэргэжлийн байгууллага, хяналт шалгалтын болон ҮЭ, ажил олгогч эздийн байгууллагын мэргэжилтэн, байцаагч, зарим ТББ-ын судлаач нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг буюу баг бүрдүүлэн шалгалт судалгаанд хамрагдсан үйлдвэр, уурхайн хөдөлмөрийн дотоод журам, хамтын болон хөдөлмөрийн гэрээг шаардлагын хэмжээнд хүргэж шинэчлэн боловсруулахад нь бодитой туслалцаа үзүүлэх.

б. Ажил олгогч, ажилтны хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдлэг, хөдөлмөрийн харилцааг зохицуулах арга барилыг дээшлүүлэх чиглэлээр:

- ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтан, хүний нөөцийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нарыг хамруулсан нэг удаагийн сургалт зохион байгуулах. /НХХЯ, АМХЭГ, УМХГ, АОЭНХолбоо, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци хамтран ОУХБ-ын дэмжлэгтэйгээр/
- хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар болон уул уурхайн үйлдвэрлэл, технологитой холбогдсон асуудлаар төрөлжсөн сургалт, семинарыг аймаг, орон нутагт жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж байх. /Аймгийн мэргэжлийн хяналтын газар, ЗДТГ, холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой/
- Орон нутагт ашигт малтмал олборлодог уурхайг түшиглэн гар аргаар ашигт малтмал олборлогчдод техникийн зөвлөгөө өгөх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны практик сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийг сурталчлах арга хэмжээ авдаг болох. /Аймгийн мэргэжлийн хяналтын газар, сумдын ЗДТГ/

2. Гар аргаар ашигт малтмал олборлох ажиллагааг зохицуулах тухай хуулийг батлан мөрдүүлэх шаардлага нэн тулгамдсан асуудал болж байгааг УИХ-д санал болгох;

3. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын ажлын үр нөлөө, уялдаа холбоог сайжруулах, аж ахуйн нэгж, байгууллагад туслах ажлыг өргөжүүлэх чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулах:

а. Үйлдвэр, уурхайд ажиллагсдын хөдөлмөрлөх эрх зүйн орчин хэрхэн бүрдсэн, хамтын болон хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журмаар хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа үндэслэл, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;

б. Ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд оролцож байгаа орон нутгийн ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах арга хэмжээ авах;

Улирлын шинжтэй үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн ажилтны ажиллаагүй хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хураамжийг цалин хөлсний доод хэмжээгээр тооцож ажил олгогч төлж байх Хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг ашигт малтмал олборлох үйлдвэр, уурхайд чанд мөрдүүлж хэвших.

Нийгмийн даатгалын болон Гар аргаар ашигт малтмал олборлох тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ялангуяа гар аргаар ашигт малтмал олборлогчдыг нийгмийн даатгалд хамруулах оновчтой арга, хэлбэрийг сонгож хэрэглэхэд санаачилгатай хандаж ажиллах;

с. УМХГ, уул уурхайн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллага, Налайх дүүргийн ЗДТГ-тай хамтран Налайхын үйлдвэрлэлийн болон гар аргаар нүүрс олборлогсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хэрхэн хангагдаж буй байдалд иж бүрэн шалгалт судалгаа хийж, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.

Түүнчлэн аймгийн Мэргэжлийн хяналтын газар эрх бүхий бусад байгууллагатай хамтран орон нутагт ажиллаж байгаа ашигт малтмал олборлох үйлдвэр, уурхайд хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд төлөвлөгөөт болон төрөлжсөн шалгалт судалгаа явуулж байх нь зүйтэй.

4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар дараах асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хайгуулын лицензээр олборлолт явуулдаг, эзэмшлийн талбайдаа хувиараа нүүрс олборлогчдыг ажиллуулан түрээсийн төлбөр авдаг, нөхөн сэргээлтийг зохих журмын дагуу хийдэггүй зэрэг зөрчил, дутагдлыг гаргахгүй байх нөхцөл бүрдүүлэх;

Уул уурхайн бага оврын техник төхөөрөмж, ковш, тросс болон ажлын бусад нэн шаардлагатай багаж хэрэгсэл, гэрэлтүүлэгч, хошуувч, нүдний шил, усны гутал, цув зэрэг бие хамгаалах хэрэгслийг харилцан ашигтай нөхцөлөөр нэгдсэн журмаар нийлүүлж борлуулан гар аргаар ашигт малтмал олборлогсдын ажиллах нөхцөлийг сайжруулахад туслалцаа үзүүлэх.

Үйлдвэрлэл өргөжихийн хэрээр орон нутгийн иргэд гар аргаар ашигт малтмал олборлогсдоос ажилчид элсүүлэх, тэд нараар боломжтой ажлыг харилцан ашигтай гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, олборлосон ашигт малтмалыг нь тохиролцооны үнээр худалдан авах болон орон нутгийн иргэдэд ашиг тустай арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглэлээр гурвалсан гэрээ байгуулах зэргээр ашиглалтын лицензтэй уурхай, гар аргаар ашигт малтмал олборлогсод болон орон нутгийн захиргааны байгууллагын хоорондын зохистой түншлэлийг бий болгох боломж нөхцөлийг судлан зохих чиглэл өгч ажиллах;

5. “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай” ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар Конвенци, монгол Улсын “Хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уул уурхайн олборлох салбарт хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг таслан зогсооход чиглэгдсэн дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд ялангуяа уурхайд хүүхэд ажиллахын эрсдэл, хор уршиг, мөнгөн устай харьцахын хортой нөлөөллийн талаархи эцэг, эх, хүүхэд, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх
- Алт, нүүрс, жонш болон давс олборлох үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдийн талаархи судалгаа, мэдээллийн сан бий болгож ашиглах, хүүхдийн

хөдөлмөрийн талаархи мэдээллийг Үндэсний статистикийн мэдээлэл цуглуулалтын тогтолцоонд хамруулах арга хэмжээ авах;

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох улмаар устгахад чиглэгдсэн хөдөлмөрийн хяналтыг боловсронгуй болгох, энэ ажилд орон нутгийн төр захиргаа, олон нийтийн хяналтыг сайжруулах;

### **ТАЙЛАН БИЧСЭН:**

КОМИССЫН ГИШҮҮН  
СУДЛААЧ

Г.ДАЛАЙЖАМЦ  
Н.БАТЖАРГАЛ  
Д.ЧИМЭДДУЛАМ